

Санхүүгийн хяналт шалгалт хийсэн дүнгийн тухай

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албаны 2019 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн 2019 оны 07 сарын 05-ны өдрийн 07/941 дугаар, Булган сумын Засаг даргын 2019 оны 07 сарын 09-ний өдрийн 01/352 дугаар “7-р цэцэрлэгийн ажиллагсдад цалин, урамшуулал хэрхэн олгож байгаад хяналт шалгалт хийх тухай” албан бичиг, Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 1/09 дугаар, 2019 оны 07 сарын 16-ны өдрийн 1/14 дугаар удирдамжийн дагуу Булган сумын 7-р цэцэрлэгийн 2017, 2018 он, 2019 оны эхний 7 сарын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ж.Оюун би 2019 оны 06 дугаар сарын 10-аас 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдрийг хүртэлх хугацаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

Шалгалт удааширсан шалтгаан нь шалгалт хийх явцад төлөвлөгөөт хяналт шалгалтаар Хангал сум, Хялганат тосгонд албан томилолтоор ажилласан, мөн Булган сумын Засаг дарга, аймгийн ЗДТГазрын Нийгмийн бодлогын хэлтсээс ирүүлсэн албан бичгийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн, уг шалгалтаар тус байгууллагын ихэнх албан хаагчид ээлжийн амралттай байсан зэрэгтэй холбоотой.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

о Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн гаргасан заавар, журам, дүрмийн хэрэгжилтийн байдал

о Орлого, зарлагын төлөвлөлт, түүний гүйцэтгэлийн байдал

о Үндсэн болон нэмэлт санжүүжилтийн дансны орлого, зарлагын гүйлгээг үндсэн баримтууд, хүнс, бараа материалын тайлан, хөрөнгийн бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн журналууд, дансны бичилтүүдтэй тулган шалгах

о Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан тэнцэл гаргалт, хөрөнгийн тооллого, тооцоо бодолт

о Байгууллага хоорондын тооцоо өглөг авлага, түүний барагдуулалт, бүртгэл тайланд тусгасан байдал

- о Цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын тогтоолт, бодолт, олголтын байдал. Үүнээс Ш.Наранцацралт 2018 оны 11 сараас, З.Ууганбаатар 2019 оны 02 сараас, Г.Наранцацралт 2019 оны 06 сард ажиллаагүй байхад цалин олгосон эсэх

- о Гадаад, дотоод албан томилолтын зардлын тооцоо төлсөн байдал

- о Зээл тусламж, эргэж төлөгдөх нөхцлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт үр дүн

- о Нягтлан бодогчийн хууль тогтоомжид заасан үүргийн биелэлт

- о Өмнөх шалгалтаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, актын барагдуулалт

- о Дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байдал

- о Шилэн дансны хуулийн хэрэгжилт

ДӨРӨВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Булган аймаг дахь Төрийн аудитын газраас Булган сумын 7-р цэцэрлэгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланг “ТҮҮВЭР”-т хамруулж, 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “ЗӨРЧИЛГҮЙ” санал дүгнэлт өгсөн байна.

2019 оны 04 сард аймгийн Татварын хэлтсээс тус цэцэрлэгийн 2014-2018 оны албан татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хийсэн хяналт шалгалтаар зөрчил илрээгүй байна.

2018 оны 09 сард Нийгмийн даатгалын хэлтсээс тус цэцэрлэгийн 2016-2017 оны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн байдлыг шалгаж, ажил гүйцэтгэх гэрээгээр ажилласан 2 иргэний хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй байсан зөрчлийг илрүүлж улсын байцаагчийн актаар шимтгэл, алдангийн нийт 126.0 мянган төгрөгийг төлүүлэхээр тогтоосныг цэцэрлэгийн төсвөөс аймгийн НДХэлтсийн нэгдсэн сангийн ХААН банкин дахь 5270260598 тоот дансанд 2018 оны 11 сарын 12-нд 126.0 мянган төгрөгийг төвлөрүүлж бүрэн барагдуулсан байна.

2016 оны 09 сард Санхүүгийн хяналт аудитын албанаас тус цэцэрлэгийн 2015 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, улсын байцаагчийн актаар 2,807.9 мянган төгрөгийн төлбөр тогтоогдсоноос өнөөдрийн байдлаар 1,781.1 мянган төгрөгийн төлбөрийг төлөөгүй, үлдэгдэлтэй.

ТАВ. ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

Багшийн журнал хөтлөлт, хүүхэд өдрийн гүйцэтгэлд дотоодын хяналтыг хийсэн ч ажлын илтгэх хуудас бичдэггүй байна.

ЗУРГАА. ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Шилэн дансны нэгдсэн сайтад Булган сумын 7-р цэцэрлэг нь 2017 онд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 2018 онд мэдээлбэл зохих 149 мэдээллийг бүрэн тогтоосон хугацаанд нь мэдээлсэн байна.

Мэдээлэл байршуулсан байдлыг шалгаж үзэхэд **2017 онд** таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 13 удаагийн 369,789.5 мянган төгрөгийн орлогын гүйлгээнээс 9 удаагийн 265,971.7 мянган төгрөгийн орлогын гүйлгээг байршуулж 4 удаагийн 103,817.7 мянган төгрөгийн гүйлгээг байршуулаагүй, 12 сар, бүтэн жилийн төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн тайлбарыг мэдээлээгүй, өмч хөрөнгөтэй холбоотой 1-7 сарын шийдвэрийг байршуулахдаа батлагдсан хүснэгтээр бөглөөгүй PDF-ээр тавьсан, мөн 4 сарын өмч хөрөнгөтэй холбоотой шийдвэрийн мэдээлэлд 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан мэдээлсэн, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, бүтэн жилийн санхүүгийн тайлангийн мэдээллийг “0” гэж мэдээлсэн.

2018 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө мэдээлэлд худалдан авах бараа, ажил, үйлчилгээ төлөвлөсөн ч бүтэн жилээр мэдээлэх худалдан авах ажиллагааны тайлан мэдээллийг худалдан авалт хийгдээгүй гэж мэдээлсэн.

ДОЛОО. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШИЙДВЭРЛЭСЭН АСУУДАЛ

Булган сумын долдугаар цэцэрлэг нь үндсэн 4, салбар цэцэрлэгт 2 нийт 6 бүлэгт дунджаар 128 хүүхэд хамруулж сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг хүргэн ажиллаж байна.

Тус сумын долдугаар цэцэрлэгийн 2017 он, 2018 он, 2019 оны эхний 7 сарын хугацааны касс, харилцах, аж ахуйн баримт, хөрөнгийн бүртгэл, байгууллагын удирдлагын гаргасан шийдвэр, цалингийн карт, ажлын цаг ашиглалтын бүртгэл, багшийн ирцийн бүртгэл, тайлан баланс, хөдөлмөрийн дотоод журам, агуулахын бүртгэл, багш, ажиллагсдын улирлын ажлын тайлан, 21 албан хаагчийн нийгмийн даатгалын дэвтэр, 8 албан хаагчийн мэргэжлийн зэргийн үнэмлэх, бусад байгууллагаас хийсэн шалгалтын материал зэрэг баримт материалуудад тулгуурлан эрхлэгч Б.Мягмарцэнд, нягтлан бодогч Б.Эрдэнэчимэг, нягтлан бодогч асан Д.Баярчимэг, нярав Д.Жавзандулам нарыг байлцуулан, бусад холбогдох хүмүүсээс тайлбар тодруулга, холбогдох баримт материалуудыг авч төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийв.

Тус цэцэрлэгийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааны нэгдүгээр гарын үсгийг 2017 оны 01 сарын 01-ээс 2019 оны 07 сарын 16-ны өдөр хүртэл Б.Мягмарцэнд, хоёрдугаар гарын үсгийг 2017 оны 01 сарын 01-ээс 08 сарын 22-ны өдөр хүртэл Д.Баярчимэг, 2017 оны 08 сарын 23-аас 2019 оны 07 сарын 16-ний өдөр хүртэл Б.Эрдэнэчимэг нар зурсан ба сумын төрийн санд бүртгэлийн 100041415204 тоот, нэмэлт санхүүжилтийн 100041415408 тоот данстайгаар хөрөнгө мөнгийг захиран зарцуулж ирсэн байна.

Шалгалтанд хамрагдсан хугацаанд тус байгууллагын нярав эд хариуцагчаар Д.Жавзандулам ажилласан.

Нягтлан бодох бүртгэл болон няравын тайланг (2018 оноос) санхүүгийн тооцоолох “СТS” программаар бүртгэн хөтөлжээ.

7.1 Бүтэц, орон тоо:

Байгууллагын даргын 2017 оны 01 сарын 02-ны өдрийн Б/01 дугаар тушаалаар тайлант онд эрхлэгч, бүлгийн багш 6, туслах багш 6, тогооч 3, сахиул 2,

арга зүйч, дуу хөгжмийн багш, нягтлан бодогч, нярав, үйлчлэгч, цагаан хэрэглэл угаагч, архив бичиг хэрэг тус бүр 1 нийт 25 орон тоотой ажиллахаар баталж, 2017 оны 01 сарын 12-ны өдрийн Б/02 дугаар тушаалаар бүлгийн багш 7, туслах багш 6, тогооч 3, сахиул 2, арга зүйч, дуу хөгжмийн багш, нягтлан бодогч, нярав, үйлчлэгч тус бүр 1 нийт 23 орон тоонд ажиллах багш, ажиллагсдын үндсэн цалинг тогтоосон.

2018 онд эрхлэгчийн 01 сарын 02-ны өдрийн Б/1 дугаар тушаалаар тайлант онд эрхлэгч, бүлгийн багш 7, туслах багш 7, тогооч 3, харуул 3, арга зүйч, дуу хөгжмийн багш, нягтлан бодогч, нярав, үйлчлэгч, цагаан хэрэглэл угаагч, гал тогоонд туслах ажилтан тус бүр 1 нийт 28 орон тоотой ажиллахаар баталж, 01 сарын 02-ны өдрийн Б/2 дугаар тушаалаар бүлгийн багш 6, туслах багш 6, тогооч 3, сахиул 2, арга зүйч, дуу хөгжмийн багш, нягтлан бодогч, нярав, үйлчлэгч тус бүр 1 нийт 22 орон тоонд ажиллах албан хаагчдын үндсэн цалинг тогтоосон байна.

2019 онд эрхлэгчийн 01 сарын 03-ны өдрийн А/1 дугаар тушаалаар тайлант онд эрхлэгч, бүлгийн багш 7, туслах багш 7, тогооч 3, харуул 3, арга зүйч, дуу хөгжмийн багш, нягтлан бодогч, нярав, үйлчлэгч, цагаан хэрэглэл угаагч, гал тогоонд туслах ажилтан, эмч, манаач тус бүр 1, архивын ажилтан 0.5 нийт 31 орон тоотой ажиллахаар баталж, 01 сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар бүлгийн багш 6, туслах багш 6, тогооч 3, сахиул 1, харуул 2, арга зүйч, дуу хөгжмийн багш, нягтлан бодогч, нярав, үйлчлэгч, туслах ажилтан тус бүр 1 нийт 24 орон тоонд ажиллах багш, ажиллагсдын үндсэн цалинг тогтоосон байна.

Тус цэцэрлэгийн нягтлан бодогчоор ажиллаж байсан Б.Эрдэнэчимэгийг 2019 оны 03 сарын 29-ний өдрөөс чөлөөлж, 2019 оны 04 сарын 01-ээс тус цэцэрлэгийн нягтлан бодогчийн албан тушаалыг хавсруулж ТҮ-8-2 дахь шатлалын үндсэн цалингийн 40 хувиар цалинжуулан ажиллуулж байна.

Сахиул Р.Баттулгыг 2018 оны 08 сарын 01-ээс, сахиул Б.Хатанбаатарыг 2019 оны 02 сарын 01-ээс чөлөөлсөн, харуулын албан тушаалд Ж.Лундаа, Б.Цэрэнтогтох нарыг 2018 оны 09 сарын 05-аас, М.Баярцогтыг 2019 оны 02 сарын 15-аас томилсон байна.

Цагаан хэрэглэл угаагчийн ажлыг үйлчлэгч Б.Дулмаад хавсруулж үндсэн цалингийн 40 хувиар 2017 оны 01-05 сард 760.1 мянган төгрөгийн хавсран ажилласны нэмэгдэл олгосон ба тус ажилтан 2017 оны 08 сарын 21-ээс ажлаас чөлөөлөгдсөн байна.

Туслах тогоочоор ажиллаж байсан Б.Цэрэндолгорыг 2017 оны 08 сарын 21-ээс чөлөөлж, уг өдрөөс үйлчлэгчийн албан тушаалд томилон угаагчийн ажлыг хавсруулж үндсэн цалингийн 40 хувиар 2017 оны 9-12 сард 664.8 мянган төгрөг, 2018 оны 01-05, 08-12 сард 1,592.3 мянган төгрөг, 2019 оны 01-06 сард 1,163.1 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна.

7.2 Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:

2017 онд улсын төсвөөс авах санхүүжилтийг 337,094.0 мянган төгрөгөөр төлөвлөж, батлагдсан төсөвт өөрчлөлт оруулан 35,470.7 мянган төгрөг нэмж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 372,564.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, нэмэлт санхүүжилтийн дансаар БСУГазраас улсын математикийн 53-р олимпиадад оролцогчдын хоолны зардалд 168.0 мянган төгрөг, “Ногоон гэрэл цагаан шугам”-ын шагналын 180.0 мянган төгрөг орж бүгд 372,912.7 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн ажиллаж, үйл ажиллагааны зардалд 372,874.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 38.1 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөвт зардлын хэтрэлт, хэмнэлтийг зардлын ангилалаар нь авч үзвэл:

- Байгууллагын ажилтан, албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 218,903.8 мянган төгрөг төлөвлөснөөс 218,867.9 мянган төгрөгийг зарцуулж 35.9 мянган төгрөг, Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 56,572.3 мянган төгрөг төлөвлөснөөс 56,571.7 мянган төгрөгийг зарцуулж 0.6 мянган төгрөг, Нормын хувцас зөөлөн эдлэл худалдан авах зардалд 727.6 мянган төгрөг төлөвлөснөөс 727.4 мянган төгрөгийг зарцуулж 0.2 мянган төгрөг, Нэмэлт санхүүжилтийн 348.0 мянган төгрөгийн орлогоос 166.9 мянган төгрөгийг хоолны зардалд, 180.0 мянган төгрөгийг хичээл сургалт үйлдвэрлэлийн дадлагын зардалд зарцуулж 1.1 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлаас 0.3 мянган төгрөг тус тус зарцуулагдаагүй үлдсэн ба төсөвт төвлөрүүлсэн байна.

- Эм, эмнэлгийн хэрэгслийн зардалд 140.4 мянган төгрөг, хоол хүнсний зардалд 41,515.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 391.4 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 190.1 мянган төгрөг, ном хэвлэлд 64.6 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 114.7 мянган төгрөг, хичээл сургалт үйлдвэрлэлийн дадлагын зардалд 4,645.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 6,900.0 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох тэтгэмжид 13,656.4 мянган төгрөг тус тус батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан байна.

- Урсгал завсарын зардлыг 8,399.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 1,179.0 мянган төгрөгийг зарцуулж 7,220.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 406.2 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 306.2 мянган төгрөгийг зарцуулж 100.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 7,099.9 мянган төгрөгөөр төлөвлөж 5,851.4 мянган төгрөгийг зарцуулж 1,248.5 мянган төгрөг, хангамж бараа материалын төлөвлөгдсөн зардлаас 8,022.2 мянган төгрөг бүгд 16,590.7 мянган төгрөгөөр авто машины зогсоол барих засварын материал худалдан авах, авто машины зогсоол хийлгэсэн ажлын хөлсөнд, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авахад зарцуулжээ.

2018 онд улсын төсвөөс авах санхүүжилтийг 407,913.8 мянган төгрөгөөр төлөвлөж, тодотголоор 4,239.8 мянган төгрөг нэмж, төсөвт зардлыг 412,153.6 мянган төгрөгөөр баталжээ.

Гүйцэтгэлээр санхүүжилтийг батлагдсаны дагуу бүрэн авч, нэмэлт санхүүжилтийн дансаар БСУГазраас сургуулийн өмнөх боловсролын багш нарын сургалтын цай хоолны зардалд 897.0 мянган төгрөг, ажиллагсдын нэмэгдэл цалингийн 889.9 мянган төгрөг орж бүгд 413,940.5 мянган төгрөгийн эх үүсвэр

бүрдүүлэн, үйл ажиллагааны зардалд 413,817.9 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 122.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөвт зардлын хэтрэлт, хэмнэлтийг зардлын ангилалаар нь харуулбал:

- Байгууллагын ажилтан, албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд зарцуулахаар батлагдсан 247,325.0 мянган төгрөг дээр нэмэлт санхүүжилтийн дансаар 889.9 мянган төгрөг нэмэгдэж, гүйцэтгэлээр 248,214.9 мянган төгрөгийг бүрэн зарцуулсан.

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 57,514.8 мянган төгрөг төлөвлөснөөс 57,514.4 мянган төгрөгийг зарцуулж 0.446 мянган төгрөг, Дотоод албан томилолтын зардалд 435.9 мянган төгрөг төлөвлөснөөс 430.2 мянган төгрөгийг зарцуулж 5.7 мянган төгрөг, Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 254.100 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 254.082 мянган төгрөгийг зарцуулж 0.018 мянган төгрөг, Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлыг 243.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 234.0 мянган төгрөгийг зарцуулж 9.0 мянган төгрөг, Нэмэлт санхүүжилтийн 889.900 мянган төгрөгийн орлогоос 889.881 мянган төгрөгийг ажиллагсдын нэмэгдэл цалинд зарцуулж 0.019 мянган төгрөг, 897.0 мянган төгрөгийн орлогоос 789.8 мянган төгрөгийг багш нарын сургалтын цай хоолны зардалд зарцуулж 107.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 0.186 мянган төгрөг тус тус зарцуулагдаагүй үлдэж төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

- Эм, эмнэлгийн хэрэгслийн зардалд 77.6 мянган төгрөг, хоол хүнсний зардалд 33,671.5 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэл худалдан авах зардалд 752.2 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардалд 18,860.4 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох тэтгэмжид 22,964.0 мянган төгрөг тус тус батлагдсаны дагуу зарцуулжээ.

- Урсгал завсарын зардлыг 15,392.5 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 4,658.3 мянган төгрөгийг зарцуулж 10,734.2 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлыг 2,174.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 1,659.0 мянган төгрөгийг зарцуулж 515.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 10,589.4 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 9,580.9 мянган төгрөгийг зарцуулж 1,008.2 мянган төгрөг, хангамж бараа материалын төлөвлөгдсөн зардлаас 60.5 мянган төгрөг бүгд 12,317.9 мянган төгрөгөөр биеийн тамирын талбай, тоглоомын талбай, мини дром, хашаа, сүүдрэвч, цэцэрлэгий хашаа зэргийг барихад, тавилга эд хогшил худалдан авахад зарцуулсан байна.

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 05 сарын 03-ны өдрийн А/12 дугаар тушаалаар Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34.2.2, 34.2.6, 51.4 дэх заалтууд, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 11.1.1, аймгийн Засаг даргын А/115, сумын Засаг даргын А/51 дугаар захирамжийг үндэслэн Булган суманд гарсан малын гоц халдварт шүлхий өвчиний үед хяналтын 11 постод ажилласан давхардсан тоогоор нийт 210 хүний 5 өдрийн хоолонд төсвөөс 695.3 мянган төгрөгийг хоолны зардлаас гаргаж, зарцуулсан. 03 сарын 06-нд 60 хүнд, 03 сарын

15-нд 60 хүнд, 03 сарын 24-нд 60 хүнд, 04 сарын 02-нд 15 хүнд, 04 сарын 12-нд 15 хүнд олгосон байна.

Нэмэлт санхүүжилтийн талаар:

2017 оны 05 сард Булган аймагт зохион байгуулагдсан улсын математикийн 53-р олимпиадад оролцохоор ирсэн багш, хүүхдүүдийг өөрийн байгууллагад байрлуулж, БСУГазраас орж ирсэн хоолны зардлын 168.0 мянган төгрөг, Хишиг-Өндөр сумаас үнэ төлбөргүй өгсөн хонины мах (тайланд орлогодоогүй)-аар олимпиадад оролцогчдын хоолны зардалд зарцуулсанаар зарлагын баримт үйлдэн тайланд тусгасан, тавин олголтын баримтгүй байна.

2018 онд СӨБ-ын багш нарын сургалтын цай хоолны зардлын 897.0 мянган төгрөгөөр хүнс, бараа материал худалдан авсан баримтаас өөр баримт байхгүй, нэмэгдэл цалингийн 889.9 мянган төгрөгийг багш, ажиллагсдын цалинд олгосон байна.

7.3 Ахмадын сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт:

Байгууллагын даргын шийдвэрээр Ахмад настны тухай хуулийн 14.6, 14.7 дахь заалтуудыг үндэслэн ахмад настанд үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг, хүндэтгэл үзүүлэхэд зориулан “Ахмадын сан” байгуулж, төсвийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт, цалингийн нийт сангаас жил бүр хөрөнгө төвлөрүүлж ажиллахыг нягтлан бодогчид зөвшөөрсөн байна.

Ахмадын сангийн зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, даргаар Н.Энхээг томилон, сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, тайлагнан ажиллахыг үүрэг болгож, 2017 оны 09 сарын 25-ны өдөр сангийн тэргүүн Н.Энхээгийн нэр дээр ХААН банкинд 5286150667 дугаартай хугацаагүй хадгаламжийн данс нээж, дэвтэр нээлгэхэд 5000 төгрөг байршуулсан байна.

2017 оны 09, 12 сард төсвийн үйл ажиллагааны цалингийн зардлаас 800,000 төгрөг шилжүүлж, банкинд хадгалуулсны хүүгийн орлогод 1,022 төгрөг 84 мөнгө бодогдож нийт 806,022 төгрөг 84 мөнгөний сангийн хөрөнгийн эх үүсвэрээс Цэцэрлэгийн эрхлэгчийн 2017 оны 09 сарын 26-ны өдрийн 41 дугаар (дугаар давхардсан) тушаалаар ахмадын баяраар тус байгууллагад ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан 10 ахмад настанд хүндэтгэл үзүүлж 150,000 төгрөгийн гарын бэлэг, ахмад настуудын дунд сугалаагаар ХХҮГазын харъяа амралтын газарт амрах эрхийн бичиг, ус буцалгагч, халуун тогоо өгөхөд 130,500 төгрөг, Ахмадын холбоонд 1 ахмад настны шагналд 30,000 төгрөг, эмнэлэгт хэвтсэн 1 ахмадаа эргэхэд 30,000 төгрөг, хүлээн авалтын хоол, хүнсэнд 119,500 төгрөг зарцуулах шийдвэртэй байхад 125,500 төгрөг зарцуулж илүү 6,000 төгрөг бүгд 466,000 төгрөг, банкны гүйлгээний шимтгэлд 902 төгрөг 28 мөнгө, данс хөтөлсөний хураамжид 2,000 төгрөг зарцуулж оны эцэст 337,120 төгрөг 56 мөнгө үлдсэн байна.

2018 онд урьд оны зарцуулагдаагүй үлдэгдэл 337,120.56 төгрөг дээр 09, 12 сард төсвийн үйл ажиллагааны цалингийн зардлаас 2,146,000 төгрөг орсон, эх үүсвэр тодорхойгүй 40,000 төгрөгийн орлого, банкинд хадгалуулсны хүүгийн орлогод 12,111.10 төгрөг бодогдож нийт 2,198,111.10 төгрөг нэмэгдэж, байгууллагын даргын тушаалгүй байхад сар шинийн баяраар 10 ахмад настанд 250,000 төгрөгөөр гарын бэлэг тавин олголтын баримтаар олгосон, 05 сард

ахмадуудын “Дуун цэнгүүн” зохион байгуулахад 14,500 төгрөгийг шийдвэргүй зарцуулсан, эрхлэгчийн 2018 оны 09 сарын 28-ны өдрийн А/23 дугаар тушаалаар ахмадын баяраар тус байгууллагад ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан 11 ахмад настанд 220,000 төгрөгөөр гарын бэлэг, ахмад настнуудын дунд сугалаагаар амрах эрхийн бичиг, аяганы ком, хоолны сав, чихрийн таваг, данх, халуун сав олгоход 213,000 төгрөг, хүлээн авалтын хоол хүнсний зардалд 217,000 төгрөг бүгд 650,000 төгрөг, 2018 оны 11 сарын 14-нд байгууллагын даргын тушаалгүй байхад 419,500 төгрөгийн зарлага гарсанаас 200,000 төгрөгөөр мөнгөн аяга, дурсгалын зүйл авч тус цэцэрлэгээс тэтгэвэрт гарсан ахмад настан Ч.Наранчимэгт өгч, үлдэгдэл 219,500 төгрөг үндсэн баримтгүй, 2018 оны 12 сарын 17-нд 117,500 төгрөгийн зарлага гарсан ч хаана, юунд зарцуулсан үндсэн баримтгүй, банкны гүйлгээ, хүүний шимтгэлд 3,761 төгрөг 11 мөнгө, данс хөтөлсөний хураамж 2,000 төгрөгийг зарцуулж оны эцэст 1,077,970 төгрөг 55 мөнгө үлдсэн байна.

Үүнээс гадна 2018 оны 04 сарын 23-нд бүртгэлийн үндсэн данснаас ахмадын сангийн дансанд арга зүйч Н.Энхээгийн Дархан-Уул аймагт болсон “Сайн үйл ажиллагаа” зөвлөгөөний (01.08-01.20-нд болсон) томилолтын зардлын 32.0 мянган төгрөгийг шилжүүлсэн.

2019 онд сангийн хөрөнгийн урьд оны зарцуулагдаагүй үлдэгдэл 1,077,970 төгрөг 55 мөнгөнөөс цэцэрлэгийн эрхлэгчийн 2019 оны 02 сарын 02-ны өдрийн А/4 дугаар тушаалаар сар шинийн баяраар 12 ахмад настанд 360,000 төгрөгөөр гарын бэлэг, эмнэлэгт хэвтсэн ахмад настанаа эргэхэд 30,000 төгрөг, хүргэлтийн шатахуунд 10,000 төгрөг, эрхлэгчийн 2019 оны 03 сарын 14-ний дугааргүй тушаалаар 1 ахмад настанд 100,000 төгрөгийн буцалтгүй тусламж, эрхлэгчийн 2019 оны 06 сарын 06-ны дугааргүй 50 нас хүрсэн 2 ахмад настанд (нярав Д.Жавзандулам, багш Д.Болормаа) 320,000 төгрөгөөр мөнгөн аяга, банкны гүйлгээний шимтгэлд 2,100 төгрөг, дэвтэр нээлгэхэд 1,000 төгрөг, данс хөтөлсөний хураамжид 2,000 төгрөгийг тус тус зарцуулж 2019 оны 06 сарын 06-ны байдлаар 252,870 төгрөг 55 мөнгө үлдсэн байна.

Сангийн тэргүүн Н.Энхээ нь 2019 онын 05 сарын 24-нд хувийн харилцах ХААН банкины 5270404962 дугаар данснаас хувь хүнд өгөх өөрийн өглөг 152,000 төгрөгийг данс андуурч ахмадын сангийн дансанд шилжүүлсэн ба тэр хугацаандаа буцааж тус санд шилжүүлсэн байна.

7.4 Тэтгэмжийн талаар:

Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.4 дэх заалтын дагуу 2018 онд багш Ц.Туяасайханд **18,860.4** мянган төгрөгийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж, мөн хуулийн 43.1.7а дахь заалтын дагуу **2017 онд** багш Б.Наранцэцэгт 3,236.4 мянган төгрөг, Т.Баярмаад 3,466.8 мянган төгрөг, Ц.Туяасайханд 3,651.0 мянган төгрөг, В.Мөнхцэцэгт 3,302.2 мянган төгрөг нийт **13,656.4** мянган төгрөгийн, **2018 онд** багш Д.Болормаад 3,650.7 мянган төгрөг, Н.Энхээд 3,237.3 мянган төгрөг, туслах багш П.Бурмаад 2,814.5 мянган төгрөг, Ш.Оюунчимэгт 2,564.2 мянган төгрөг, Ш.Наранцацралтад 2682.5 мянган төгрөг, С.Нарангэрэлд 2,682.5 мянган төгрөг, Ц.Цолмонд 2,517.7 мянган төгрөг,

Ч.Наранчимэгт 2,814.6 мянган төгрөг нийт **22,964.0** мянган төгрөгийн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны таван жил тутамд олгох тэтгэмжийг тус тус олгосон байна.

7.5. Цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын талаар:

2017 онд ажилтан, албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 218,903.8 мянган төгрөг төлөвлөснөөс 218,867.9 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдсэн 35.9 мянган төсөвт төвлөрүүлсэн байна.

2018 онд ажиллагсдын цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд зарцуулахаар батлагдсан 247,325.0 мянган төгрөг дээр нэмэлт санхүүжилтийн дансаар 889.9 мянган төгрөг нэмэгдэж, гүйцэтгэлээр 248,214.9 мянган төгрөгийг бүрэн зарцуулсан.

2019 онд багш ажиллагсдын цалингийн зардалд 290,276.1 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 36,284.5 мянган төгрөг батлагдсан байна.

Хагас жилийн байдлаар цалинд 164,815.9 мянган төгрөг, НДШимтгэлд 20,602.0 мянган төгрөг төсөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 152,972.0 мянган төгрөг, НДШимтгэлд 19,084.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. *(Хагас жилийн байдлаар төсвийн хуваариар цалинд 153,836.4 мянган төгрөг, шимтгэлд 19,229.7 мянган төгрөг зарцуулах.)*

Хагас жилийн байдлаар цалинд 164,815.9 мянган төгрөг, НДШимтгэлд 20,602.0 мянган төгрөг төсөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 152,972.0 мянган төгрөг, НДШимтгэлд 19,084.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

- Тус байгууллагын багш, ажиллагсад 2017 онд 1 өдрийн цалин 483.3 мянган төгрөг, 2018 онд 2 өдрийн цалин 950.4 мянган төгрөг нийт 3 өдрийн цалин 1,433.7 мянган төгрөгийг аймаг байгуулагдсаны 80 жилийн ойд хандивласан бол 2019 онд аймгийн БСУГазрын 60 жилийн ойд нэг өдрийн цалин 677.9 мянган төгрөг хандивлажээ.

- 2017 онд багш, ажиллагсад 9,100.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгож, 6,050.0 мянган төгрөгийг холбогдох урьдчилгаа авсан албан хаагчдаас бүрэн суутгасан.

10 сард эрхлэгч Б.Мягмарцэнд, арга зүйч Н.Энхээ, нягтлан бодогч Б.Эрдэнэчимэг нар тус бүр 850,000 төгрөг, багш Д.Болормаа 500,000 төгрөг нийт 3,050,000 төгрөгийн цалингийн урьдчилгаа олгож, 12 сард дараах албан хаагчдаас суутгасан байна. Үүнд: Эрхлэгч Б.Мягмарцэндээс 763,128 төгрөг, багш Н.Энхээгээс 525,915 төгрөг, нягтлан бодогч Б.Эрдэнэчимэгээс 443,691 төгрөг, багш Д.Болормаагаас 500,000 төгрөг, нярав Д.Жавзандуламаас 352,673 төгрөг, сахиул Р.Баттулгаас 464,593 төгрөг бүгд 3,050.0 мянган төгрөг.

Цалингийн урьдчилгааг “Авто машины зогсоол” барихад төсөв хүндрэлтэй байсан учраас авч, барилгын засварын материал авсан гэж холбогдох албан хаагчид тайлбарлаж байв. Үүнд: 2017 онд **Эрдэнэ бармат ХХК-иас** 10 сарын 10-нд 880,000 төгрөгөөр 80 шуудай цемент, 10 сарын 14-нд 495,000 төгрөгөөр 45 шуудай цемент, 6,000 төгрөгөөр 10 кг давс, 10 сарын 16-нд 96,000 төгрөгөөр 160 кг давс,

Булган аураг ХХК-иас 10 сарын 13–нд 1,575,000 төгрөгөөр 150 шуудай цемент нийт 3.052,000 төгрөгөөр авсан байна. Үндсэн хөрөнгийн тайланд ажлын хөлсний 3,950,000 төгрөг, засварын материалын 3,050,000 төгрөг нийт 7,000,000 төгрөгөөр тусгасан байна.

2017 оны 12 сарын 15-ны өдрийн 480 дугаартай төлбөрийн хүсэлтээр урсгал засварын зардлаас гаргаж, дээрх нэр бүхий 6 албан хаагчдад буцаан олгосон байна.

2018 онд 950.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгож бүрэн суутгасан. 2019 оны эхний 7 сарын байдлаар 4,350.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгож, 4,450.0 мянган төгрөгийг цалингаас суутгасан.

7.5.1 Ажлын цаг ашиглалтын бүртгэл хөтлөлт:

- Ажлын цаг ашиглалтын бүртгэлийг 7-р цэцэрлэгийн цаг бүртгэгч сахиул Р.Баттулга 2017 оны 01 сарын 01-ээс 2018 оны 06 сарын 04-ний өдөр хүртэл бүртгэж, 2018 оны 06 сарын 05-аас 2018 оны 07 сарын 31-ний өдөр хүртэл бүртгээгүй, нягтлан бодогч Б.Эрдэнэчимэг 2018 оны 06 сарын 05-аас 2018 оны 09 сарын 05-ны өдөр хүртэл нөхөж бүртгэсэн, цагийн бүртгэлд гарын үсэг зураагүй, 2018 оны 09 сарын 06-аас 2019 оны 02 сарын 15-ны өдөр хүртэл харуул Б.Цэрэнтогтох, Ж.Лундаа нар, 2019 оны 02 сарын 16-наас 2019 оны 06 сарын 25-ны өдөр хүртэл харуул Б.Цэрэнтогтох, Ж.Лундаа, М.Баярцогт нар 2019 оны 06 сарын 26-аас 2019 оны 07 сарын 22-ны өдөр хүртэл харуул Б.Цэрэнтогтох, М.Баярцогт нар бүртгэсэн байна. Сахиул Р.Баттулга нь 2018 онд эрхлэгч Б.Мягмарцэнд, арга зүйч Н.Энхээ нарын 06 сарын 05-аас 06 сарын 31, багш Т.Баярмаа, Б.Наранцэцэг, Б.Бадамханд, Д.Гэрэлчимэг нарын 06 сарын 05-аас 06 сарын 16-ны өдөр хүртэлх ажлын цаг ашиглалтын бүртгэлийг нягтлан бодогч Б.Эрдэнэчимэг нөхөж бүртгэсэн байхад сахиул Р.Баттулга өөрөө бүртгэсэн мэтээр гарын үсэг зурсан, ахлах тогооч Н.Гангаамааг 2018 оны 06 сарын 08-аас 06 сарын 15-ны өдөр хүртэл ажлын 6 өдөр өвчтэй байхад ажилласнаар бүртгэсэн, Бүх ажиллагсдын 2018 оны 12 сарын 31-ний ажилдаа ирсэн цагийг бүртгээд, явсан, завсарласан, завсарлаад ирсэн цаг байхгүй.

- Булган сумын долдугаар цэцэрлэгийн салбар 5-р цэцэрлэгийн ажлын цаг ашиглалтын бүртгэлийг сахиул Б.Хатанбаатар 2017 оны 01 сарын 01-ээс 2019 оны 01 сарын 31-ний өдөр хүртэл бүртгэсэн байна.

Салбар цэцэрлэгийн сахиул Б.Хатанбаатар нь **2017 онд** 01 сарын 01-ээс 18-ны өдрүүдэд өөрийнхөө цагийг бүртгэсэн ч гарын үсэг зураагүй, 01 сарын 19-өөс 31 хүртэл ажилласан бүртгэлгүй байхад цалин бүтэн бодогдсон, 01 сард туслах багш Ц.Цолмон, 02 сард тогооч Ж.Оюундалай, 03 сард туслах багш Ч.Наранчимэг нарын ажилласан цагийг бүртгэсэн ч гарын үсэг зураагүй, сахиул Ш.Болдын 07 сарын 24-өөс 31-ний өдрүүдэд ажилласан эсэхийг “24 цаг” гэж тэмдэглэсэн, гарын үсэг зурагдаагүй, сахиул Ш.Болдын 08 сарын 01-ээс 14-ний өдрүүдийн ажлын цагийг ээлжийн амралттай байсан сахиул Б.Хатанбаатар бүртгэсэн ба хэн нь ажилласан эсэх тодорхойгүй, **2018 онд** 05 сарын 01-ээс 15 хүртэл тогооч Ж.Оюундалайг өвчтэй байх хугацаанд М.Саранцэцэгийг салбараас төв цэцэрлэгт, Ц.Даариймааг төвөөс салбар цэцэрлэгт түр шилжүүлэн ажиллуулсан ч энэ өдрүүдэд ажилласан цагийг бүртгээгүй, өөрсдийн үндсэн ажлын байранд нь ажилласнаар буруу

бүртгэсэн, сахиул Б.Хатанбаатар 08 сарын 27-нд амраад ажилдаа орсон мөртөл үүнээс өмнөх өдрүүдэд ажилдаа орсон багш, туслах багш, тогооч нарын цагийг бүртгэсэн, өөрийн цагийг 24 цаг гэж буруу бүртгэсэн.

2019 онд 02, 03 сар, 06 сар, 07 сарын 01-ээс 09-ний өдрүүдэд багш, ажиллагсдын цагийг хэн бүртгэсэн нь тодорхойгүй, “Ууган” гэх хүн бүртгэсэнээр гарын үсэг зурагдсан, 04, 05 сард цаг бүртгэгчийн гарын үсэг зурагдаагүй байна.

7.5.2 Үр дүнгийн урамшуулалт цалин:

Эрхлэгч Б.Мягмарцэндэд аймгийн Засаг даргын 2017 оны А/200, А/514 дугаар захирамжаар 01-6, 8-12 сард үндсэн цалингийн 20-25 хувиар тооцож 1,620.4 мянган төгрөг, 2018 оны Б/46, А/574 дугаар захирамжаар 01-12 сард үндсэн цалингийн 25 хувиар тооцож 2,003.7 мянган төгрөг, 2019 оны А/225 дугаар захирамжаар 1-7 сард үндсэн цалингийн 25 хувиар тооцож 1,518.8 мянган төгрөг нийт 5,142.9 мянган төгрөгийн үр чадварын нэмэгдэл, аймгийн Засаг даргын 2017 оны А/238, А/391, А/512, А/634 дугаар захирамжаар 1-4-р улиралд үндсэн цалингийн 45%-иар тооцож 1,280.2 мянган төгрөг, 2018 оны А/233, А/583, А/696, А/712 дугаар захирамжаар 1-4-р улиралд үндсэн цалингийн 25-45 хувиар тооцож 1,024.2 мянган төгрөг, 2019 оны А/226 дугаар захирамжаар 1-р улиралд үндсэн цалингийн 45 хувиар тооцож 402.0 мянган төгрөг нийт 2,706.4 мянган төгрөгийн ажлын үр дүнгийн урамшуулалт цалин, аймгийн Засаг даргын 2018 оны 10 сарын 12-ны А/614 дугаар захирамжаар Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийн бэлтгэл ажлыг хангахад идэвхи, зүтгэлтэй оролцсонд нэг сарын үндсэн цалингаар, сумын Засаг даргын 2016 оны Б/25, 2017 оны Б/34, 2018 оны Б/17 дугаар захирамжаар сумын Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтээр “А” үнэлгээгээр дүгнэгдсэнд үндсэн цалингийн 80 хувь болон нэг сарын үндсэн цалингаар нийт 2,702.7 мянган төгрөгийн шагналт цалин, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 сарын 09-ны өдрийн 67 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2017 оны 12 сарын 21-ний өдрийн А/635 дугаар захирамжаар 300.0 мянган төгрөгийн урамшуулалт цалин тус тус олгосон байна.

Багш, ажиллагсдад 2017 онд цэцэрлэгийн эрхлэгчийн Б/18, Б/19, Б/24, Б/25, 42, 43, 61 дугаар тушаалуудыг үндэслэн 1-р улиралд 21 хүнд 3,880.0 мянган төгрөг, 2-р улиралд 22 хүнд 3,922.2 мянган төгрөг, 3-р улиралд 20 хүнд 19-35 хувиар тооцож 2,339.6 мянган төгрөг, 4-р улиралд 22 хүнд 41-45 хувиар тооцож 4,645.1 мянган төгрөг нийт 14,786.9 мянган төгрөг, **2018 онд** цэцэрлэгийн эрхлэгчийн А/09, А/18, А/24, А/32 дугаар тушаалуудыг үндэслэн 1-р улиралд 23 хүнд 18-60 хувиар 5,361.5 мянган төгрөг, 2-р улиралд 24 хүнд 28-50 хувиар 5,025.7 мянган төгрөг, 3-р улиралд 23 хүнд 15-38 хувиар 2,849.2 мянган төгрөг, 4-р улиралд 24 хүнд 20-60 хувиар тооцож 5,593.9 мянган төгрөг нийт 18,830.3 мянган төгрөг, **2019 онд** цэцэрлэгийн эрхлэгчийн А/14, А/23 дугаар тушаалыг үндэслэн 1-р улиралд 27 хүнд 15-58 хувиар тооцож 7,180.4 мянган төгрөг, 2-р улиралд 22 хүнд 40-59 хувиар тооцож 6,805.9 мянган төгрөг нийт 13,986.3 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн урамшуулалт цалин тус тус олгожээ.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 сарын 09-ны өдрийн 67 дугаар тогтоолыг үндэслэн цэцэрлэгийн эрхлэгчийн 2017 оны 12 сарын 20-ны өдрийн 63 дугаар тушаалаар 28 багш, ажиллагсдад 6,600.0 мянган төгрөгийн урамшуулалт цалинг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас гаргаж, олгосон байна.

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2019 оны 03 сарын 21-ний өдрийн Б/8 дугаар тушаалаар нягтлан бодогч Б.Эрдэнэчимэгт санхүүгийн тайлангийн аудитаар ЗӨРЧИЛГҮЙ санал дүгнэлтээр үнэлэгдсэнд нэг сарын үндсэн цалин 654.2 мянган төгрөгөөр шагнаж урамшуулсан байна.

2017 онд байгууллагын “Оны тэргүүний ажилтан”-аар сахиул Р.Баттулгыг шалгаруулж, 100.0 мянган төгрөгөөр (цалингийн зардлаас), 2018 онд байгууллагын “Оны тэргүүний багш”-аар багш Д.Гэрэлчимэг, “Оны тэргүүний ажилтан”-аар тогооч Н.Гангаамаа нарыг шалгаруулж тус бүр 200.0 мянган төгрөгөөр (цалингийн зардлаас) шагнаж урамшуулсан байна.

Бүлгийн багш Д.Болормаад тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 06 сарын 22-ны А/18 дугаар тушаалаар хоёрдугаар улирлын ажлын үр дүнгийн урамшуулалт үндсэн цалингийн 40 хувиар олгохоор шийдвэрлэж, 243,383 төгрөг бодогдсоноос ЭМНДШимтгэлд 26,772 төгрөг, ХХОАТатварт 8,328 төгрөг, аймгийн 80 жилийн ойн хандивт 21,164 төгрөг бүгд 56,264 төгрөг суутгаж, гарт 187,119 төгрөгийн урамшуулалт цалин олгосон байна.

Багш Д.Болормаа нь 2018 оны 07 сарын 04-нд няравын ХААН банкины 5270405014 дугаар дансанд хоёрдугаар улирлын үр дүнгийн урамшууллын буцаалтад 220,000 төгрөг шилжүүлсэн. Нярав хүлээн авсан ч бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй, уг мөнгөөр “Эрдэнэ” барилгын дэлгүүрээс 115,000 төгрөгөөр 4 ш хар панер, 73,000 төгрөгөөр 10 кг шар, цэнхэр, ногоон, цагаан будаг, 10,000 төгрөгөөр 4 ш пегмент, 10,000 төгрөг будагны зөрүү, 12,000 төгрөгөөр 2 ш гинж авч, байгууллагын засварын материалд зарцуулсан гэж хүлээлгэн өгсөн гарын үсэггүй, тамга тэмдэг дарагдаагүй зарлагын баримтыг шалгалтын явцад ирүүлсэн./Баримтыг хавсаргав./

Байгууллагын даргын тушаалыг үндэслэн **2017 онд** нягтлан бодогч асан Д.Баярчимэгт 1-2-р улиралд 41-45%-иар 482.3 мянган төгрөг, нягтлан бодогч Б.Эрдэнэчимэгт 3-4-р улиралд 22-44%-иар 470.2 мянган төгрөг, нярав Д.Жавзандуламд 1-4-р улиралд 26--45%-иар 693.0 мянган төгрөгийн, **2018 онд** нягтлан бодогч Б.Эрдэнэчимэгт 1-4-р улиралд 29-45%-иар 912.4 мянган төгрөг, нярав Д.Жавзандуламд 1-4-р улиралд 25--45%-иар 742.8 мянган төгрөгийн, 2019 онд нягтлан бодогч Б.Эрдэнэчимэгт 1-р улиралд 45%-иар 294.4 мянган төгрөг, нярав Д.Жавзандуламд 1-2-р улиралд 45%-иар 492.4 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн урамшуулалт, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 сарын 09-ны өдрийн 67 дугаар тогтоолыг үндэслэн нягтлан бодогч асан Д.Баярчимэгт 225.0 мянган төгрөг, Б.Эрдэнэчимэгт 100.0 мянган төгрөг, нярав Д.Жавзандуламд 300.0 мянган төгрөгийн нэг удаагийн урамшуулалт цалин тус тус олгосон байна.

7.5.3 Ур чадварын нэмэгдэл:

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2017 оны Б/04, Б/06, Б/07, Б/12, Б/19, Б/20, Б/21, Б/22, 38, 39, 50, 51, 55, 59, 60 дугаар, 2018 оны А/3, А/5, А/6, А/7, А/8, А/11, А/13, А/15, А/17, А/20, А/21, А/25, А/27, А/28, А/29, А/31 дугаар, 2019 оны Б/6, А/7, А/8, А/15, А/16, А/19, А/20, А/22 дугаар тушаалуудыг үндэслэн 2017 онд 19 албан хаагчид үндсэн цалингийн 5-30 хувиар 5,666.2 мянган төгрөг, 2018 онд 22 албан хаагчид үндсэн цалингийн 17-30 хувиар 7,206.2 мянган төгрөг, 2019 онд 16 албан хаагчид үндсэн цалингийн 10-25 хувиар 4,546.0 мянган төгрөг нийт давхардсан тоогоор 57 албан хаагчид 17,418.4 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл цалин олгосон байна.

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2019 оны 04 сарын 22-ны өдрийн А/15 дугаар тушаалаар “Бид судлаач—2019” ажилд идэвхи санаачлагатай бусдыгаа манлайлан ажилласан /илтгэл/ гэж нэр бүхий 6 багш, албан хаагчид үндсэн цалингийн 25 хувиар ур чадварын нэмэгдэл олгохоор шийдвэрлэж, албан хаагч тус бүрийн хувийн харилцах дансанд шилжүүлсэн. Үүнээс багш Т.Баярмаа, Н.Энхээ нарт үндсэн цалингийн 20 хувиар дутуу олгосон.

Харин дуу хөгжмийн багш Д.Алтанцэцэгт ур чадварын нэмэгдлийг үндсэн цалингийн 25 хувиар 189,528 төгрөгийг 4 сарын цалин дээр нэмэгдлээр бодож, хувийн харилцах дансанд нь 2019 оны 04 сарын 22-нд шилжүүлсэн ч дуу хөгжмийн багш Д.Алтанцэцэгээс 2019 оны 04 сарын 23-нд нярав Д.Жавзандуламын ХААН банкны 5270405014 дугаар дансанд “ур чадварын буцаалт” гэж 150,900 төгрөгийг буцааж шилжүүлсэн байна.

Мөн эрхлэгчийн 2019 оны 05 сарын 23-ны өдрийн А/16 дугаар тушаалаар “Бүтээлч багш 2019” ажилд идэвхи санаачлагатай бусдыгаа манлайлан ажилласан гэж нэр бүхий 5 багш, албан хаагчид үндсэн цалингийн 25 хувиар ур чадварын нэмэгдэл олгохоор шийдвэрлэж, албан хаагчдын тус бүрийн хувийн харилцах дансанд шилжүүлсэн байна.

Үүнээс дуу хөгжмийн багш Д.Алтанцэцэгт ур чадварын нэмэгдлийг үндсэн цалингийн 25 хувиар 189,528 төгрөгийг 5 сарын цалин дээр нэмэгдлээр бодож, хувийн харилцах дансанд нь 2019 оны 05 сарын 24-нд шилжүүлсэн ч дуу хөгжмийн багш Д.Алтанцэцэгээс 2019 оны 05 сарын 24-нд нярав Д.Жавзандуламын ХААН банкны 5270405014 дугаар дансанд “mut zuruu” гэж 150,000 төгрөгийг буцааж шилжүүлсэн байна.

Дуу хөгжмийн багш Д.Алтанцэцэгээс буцааж авсан ур чадварын нэмэгдлийн 300,900 төгрөгөөс 300,000 төгрөгөөр мөнгөн аяга авч өөр ажилд шилжсэн 2 албан хаагчид зарцуулсан гэж байгаа ч үндсэн баримт байхгүй, тайлан гаргаагүй байна.

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 12 сарын 14-ний өдрийн А/31 дугаар тушаалаар “Нойрсолт” үзүүлэх ажлын хүрээнд хүүхдэд олгох дадал чадварыг эзэмшүүлэн материаллаг орчинг бүрдүүлэн, бүтээлч идэвхи санаачлагыг өрнүүлэн ажилласан гэж нэр бүхий 5 туслах багшид үндсэн цалингийн 30 хувиар ур чадварын нэмэгдэл олгохоор шийдвэрлэж, албан хаагчдын тус бүрийн хувийн харилцах дансанд шилжүүлсэн байна. Үүнээс туслах багш Ш.Оюунчимэгт үндсэн

цалингийн 30 хувиар 138,465 төгрөгийг 12 сарын цалин дээр нэмэгдлээр бодож, хувийн харилцах дансанд нь шилжүүлж олгосон байна.

Гэвч туслах багш Ш.Оюунчимэг нь “Нойрсолт” үзүүлэх ажлын хүрээнд шалгараагүй байхад Ш.Оюунчимэгийн нэр дээр ур чадварын нэмэгдэл олгохоор бичиж, буцаан авахдаа багш ажиллагсдын хуримтлалаас 100,000 төгрөгийг Ш.Оюунчимэгийн хуримтлуулсан мөнгөнөөс тооцож буцааж өгсөнөөр авсан байна. Уг мөнгөөр урлагийн наадмын үеэр хөгжим түрээсэлсэн Олонцэцэг гэх хүнд өгсөн гэж нярав тайлбарлаж байв.

2018 онд хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургалтын орчин бүрдүүлэхэд бусдыгаа манлайлан бүтээлч идэвхи санаачлагыг өрнүүлэн сургалтын орчин бүрдүүлсэн гэж 2,6 сард 20-25 хувиар нягтлан бодогч Б.Эрдэнэчимэгт 252.4 мянган төгрөг, нярав Д.Жавзандуламд 211.1 мянган төгрөг, өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж хүүхэд нэг бүрийн осол аюулгүй орчинг бүрдүүлэх ажилд санаачлагатай ажилласан гэж 9,10 сард 30 хувиар Б.Эрдэнэчимэгт 363.4 мянган төгрөг, нярав Д.Жавзандуламд 303.9 мянган төгрөг, **2019 онд** нярав Д.Жавзандуламд өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж санаачлагатай бусдыгаа манлайлан ажилласан гэж 03-5 сард 25 хувиар 410.4 мянган төгрөг, улсын архивын шалгалтанд амжилттай бэлтгэн хангалттай сайн үнэлэгдэн гэж 6 сард 25 хувиар 136.8 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.

7.5.4 Багш, ажиллагсдын хуримтлал:

Нярав Д.Жавзандуламын нэр дээр Хас банкинд 5000444836 дугаар хугацаагүй хадгаламжийн данс нээж, багш, ажиллагсдаас хураасан хуримтлалын мөнгийг төвлөрүүлдэг байна.

Багш ажиллагсдын цалингаас 2017 онд 2,748.0 мянган төгрөг, 2018 онд 3,068.0 мянган төгрөг, 2019 оны 1-06 сард цалингаас 1,788.0 мянган төгрөг суутгаж, хуримтлалын дансанд шилжүүлсэн байна. Харин багш ажиллагсдын ҮЭТатварын 500.0 мянган төгрөг, туслах багш Ш.Оюунчимэг, харуул М.Баярцогт нараас тус бүр 50.0 мянган төгрөг хуримтлалд өгсөнийг бэлнээр авч, хамт олны аялал зугаалганд зарцуулсан байна.

2017 оны 06 сарын 30-нд нэмэлт санхүүжилтийн данснаас хуримтлалын дансанд “ногоон гэрэл цагаан шугам”-ын шагналын 180.0 мянган төгрөг, 2017 оны 12 сарын 20-нд бүртгэлийн үндсэн данснаас хуримтлалын дансанд “Оны тэргүүний ажилтан”-ны шагналын 90.0 мянган төгрөг, УБ хотоос тоног төхөөрөмж ачуулсан тээврийн хөлсний 150.0 мянган төгрөг нийт 420.0 мянган төгрөгийг шилжүүлсэн, бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй.

2018 онд бүртгэлийн үндсэн дансанаас няравын ХААН банкны хувийн харилцах 5270405014 дугаар дансанд 12 сарын 23-нд Монголын багш нарын 54 дэх өдрөөр шагнагдсан албан хаагчдын шагналын дагалдах 210.6 мянган төгрөгийг шилжүүлсэнийг нярав хуримтлалын дансанд шилжүүлэн 2019 оны 01 сарын 07-нд бэлнээр авч, олгосон байна.

Нярав Д.Жавзандулам нь хуримтлалаас зарлага гарсан тухай бүрийн банкны баримт дээр хэнд, юунд зарцуулсаныг дэлгэрэнгүй, тодорхой бичиж тэмдэглэсэн сайн талтай байна.

Цаашид хуримтлалын зарцуулалтын анхан шатны баримтуудыг тухай бүр авч, хуримтлалаас зээлсэн мөнгийг бэлнээр бүрэн авсан тохиолдолд тэр дүнгээр нь хуримтлалын дансанд буцаан шилжүүлэх эс бөгөөс албан хаагчид зээлсэн мөнгөө дутуу өгсөн мэт харагдаж байгаад анхаарах.

7.5.6 ҮЭТатвар:

Багш ажиллагсдын цалингаас ҮЭТатварт сар бүр 1 хувиар тооцон 2017 оны 01-08 сарын татварыг үйлчлэгч Б.Дулмаа, 2017 оны 08 сараас одоог хүртэлх хугацааны татварыг туслах багш П.Бурмаа нарын нэр дээ нээсэн доорхи дансанд шилжүүлж, зарцуулсан байна.

2017 оны 1-8 сард цалингаас 1,081,357 төгрөг суутгаж, үйлчлэгч Б.Дулмаагийн нэр дээр нээсэн Төрийн банкны 121800054228 дугаар дансанд шилжүүлсэн ба Б.Дулмаа нь 2017 оны 08 сарын 21-ээс ажлаас чөлөөлөгдсөн байна.

2017 оны 8-12 сард 601,642 төгрөг, 2018 оны 1-12 сард 1,969,924 төгрөг, 2019 оны 01-07 сард 1,614,557 төгрөг бүгд 4,186,123 төгрөг суутгаж, туслах багш П.Бурмаагийн нэр дээр нээсэн Хас банкны 5002211124 дугаар, Төрийн банкны 120000504918 дугаар хугацаагүй хадгаламжийн дансанд тус тус шилжүүлжээ.

Үүнээс 2017 онд 160,000 төгрөг, 2018 онд 1-6, 8-12 сарын татварт 471,000 төгрөг, 2019 оны 1-5 сарын татварт 205,000 төгрөг бүгд 836,000 төгрөгийг аймгийн ҮЭХорооны 5270001804 дугаар дансанд шилжүүлсэн.

Зарцуулалт: 2018 онд Эх үрсийн баяраар 20 албан хаагчдад 300,000 төгрөгөөр гарын бэлэг тавьж олгосон баримт байхгүй, багш нарын баярын арга хэмжээний 540,000 төгрөгөөр цэцэг, хүнс, чихэр, жимс авч, амралтын газар хүргүүлсэн жолоочийн тээврийн хөлсөнд, шинэ жилийн баяраар 514,500 төгрөгөөр Хустай бэйкери ХХК-иас 26 ш бялуу авсан ч хүлээлгэж өгсөн баримт байхгүй, 2019 онд 340,000 төгрөгөөр ҮЭ-ийн 25 гишүүнээ урьдчилан сэргийлэх ЭХО оношилгоонд хамруулсан, эх үрсийн баяраар тариаланч Б.Ган-Эрдэнээс 28,000 төгрөгөөр жимс, “Гурван хас” ХХК-иас 72,000 төгрөгөөр 3 ш бялуу нийт 100,000 төгрөгөөр авсан ч хэнд олгосон эсэх баримтгүй, хамт олны аялал зугаалгаар 180,000 төгрөгөөр хонь, хамт олны аялалд зориулж 500,000 төгрөг няравт бэлнээр нийт 2,474,500 төгрөг зарцуулсан.

Нийт багш, ажиллагсдын ҮЭТатвараас 3,310,500 төгрөгийг зарцуулж, 2019 оны 07 сарын 24-ний байдлаар Төрийн банкны 120000504918 дугаар дансны үлдэгдэл 884,907 төгрөг 35 мөнгө байна.

Цаашид багш, ажиллагсдад олгосон гарын бэлэг, бялуу зэрэг зарцуулалтад хүлээн авсан хүмүүсээр гарын үсэг тухай бүрд нь зуруулж байх.

7.5.7 – Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 11 сарын 01-ний өдрийн Б/29 дугаар тушаалаар ахлах бүлгийн туслах багш **Ч.Наранчимэгийг** өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан гэж 11 сарын 01-ээс чөлөөлж, 2018 оны 11 сарын 01-ний өдрийн Б/30 дугаар тушаалаар ахлах бүлгийн туслах багшаар Б.Саранцэцэгийг 11 сарын 01-ээс ТҮБД-1-2 шатлалын 453,149 төгрөгөөр цалинжуулахаар томилсон байна.

Гэвч Ч.Наранчимэг нь 2018 оны 10 сард ажиллаагүй байхад цалин бодож олгосон, оронд нь туслах багш Б.Саранцэцэг ажилласан ч цалин бодоогүй байна.

Ахлах бүлгийн туслах багш Ч.Наранчимэгт 2018 оны 10 сард ТҮБД-1-5 шатлалын үндсэн цалин 506,633 төгрөг, орон нутгийн нэмэгдэл $40,531 / 506633 * 8\%$ /төгрөг, илүү цагийн хөлс $104,041 / 506633 / 168 * 23$ илүү ажилласан цаг $* 1.5$ /төгрөг нийт олгох 651,205 төгрөгөөс ЭМНДШимтгэлд 71,633 төгрөг, ХХОАТатварт 46,290 төгрөг, ҮЭТатварт 6,512 төгрөг, хуримтлалд 12,000 төгрөг бүгд 136,435 төгрөг суутгаж, гарт 514,770 төгрөгийн цалин бодож 2018 оны 10 сарын 22-нд, мөн эрхлэгчийн 2018 оны 10 сарын 03-ны А/24 дугаар тушаалаар 03-р улирлын үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 25%-иар олгохоор шийдвэрлэн 126,658 / $506633 * 25\%$ / төгрөг бодогдоноос ЭМНДШимтгэлд 13,932 төгрөг, ХХОАТатварт 11,272 төгрөг бүгд 25,204 төгрөг суутгаж, гарт 101,454 төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин бодож 2018 оны 10 сарын 03-нд тус тус Ч.Наранчимэгийн ХААН банкны 5270404973 дугаар дансанд шилжүүлсэн байна.

Ч.Наранчимэгийн хувийн харилцах дээрх дансанд үр дүнгийн урамшууллын 101,454 төгрөг 2018 оны 10 сарын 04-нд, цалингийн 514,770 төгрөг 2018 оны 10 сарын 22-нд тус тус орж, 2018 оны 10 сарын 23-нд бэлнээр 514,000 төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

- Цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 06 сарын 20-ны өдрийн Б/12 дугаар тушаалаар **Ч.Ганболдыг** 06 сарын 08-аас 06 сарын 18-ныг хүртэл гал тогооны тогоочийн албан тушаалд ТҮ-3-5 дахь шатлал 452,155 төгрөгөөр цалинжуулахаар түр томилсон. Ч.Ганболд нь тогооч бус машинист мэргэжилтэй, тогоочоор ажилласан бүртгэл үгүй, Булган Мээж ХХК-нд машинист /улирлын чанартай/-аар ажилладаг.

Ч.Ганболдод 2018 оны 06 сард 6 өдөр ажилласан гэж 140,732 төгрөгийн цалин бодсоноос ЭМНДШимтгэлд 15,481 төгрөг, ҮЭТатварт 1,407 төгрөг бүгд 16,888 төгрөг суутгаж, гарт 123,844 төгрөг бодож, Ч.Ганболдын ХААН банкны 5286052682 дугаар дансанд шилжүүлж, олгосон байна. (ХААН банкны гарт олгох тооцооны хүснэгтэд Ч.Ганболдын дансны дугаарыг тавиагүй байна.)

Ахлах тогооч Н.Гангаамаа нь 2018 оны 06 сарын 08-аас 06 сарын 15-ны өдөр хүртэл ажлын 6 өдөр өвчтэй байсан ба ХЧТАлдсаны тэтгэмжид 152,549 төгрөг авсан байна.

Мөн эрхлэгчийн 2019 оны 06 сарын 26-ны өдрийн Б/11 дугаар тушаалаар Чунагсүрэн овогтой Ганболдыг 2019 оны 06 сарын 26-ны өдрөөс эхлэн жижүүрийн албан тушаалд түр томилж, ТҮ-1-4 дэх шатлал 462,826 төгрөгөөр цалинжуулахаар шийдвэрлэсэн ч Ч.Ганболд нь тус байгууллагад ажиллаагүй байна.

Гэвч 2019 оны 06 сарын 26-аас хойш одоог хүртэл харуулаар Б.Цэрэнтогтох, М.Баярцогт нар ажилласан ба 06 сарын 26-нд харуул Ж.Лундаагийн цагийн бүртгэлд буй нэрийн ард хэн бичсэн нь тодорхойгүйгээр үргэлжлүүлж “Ч.Ганболд” гэж нэмж бичин 06 сарын 28-нд ажилласнаар, 07 сард харуулууд Ч.Ганболд гэж цагийн бүртгэлд нэр нээж 07 сарын 01, 04, 07-ны өдрүүдэд 24 цагаар ажилласанаар бүртгэсэн.

Нягтлан бодогч Б.Эрдэнэчимэг нь 2019 оны 07 сард 20 өдөр ажилласан гэж үндсэн цалин 462,826 төгрөг, илүү цагийн хөлсөнд $277,696 / 462826 / 160 * 96$ /төгрөг

нийт олгох 740,522 төгрөгөөс ЭМНДШимтгэлд 85,160 төгрөг, ХХОАТатварт 47,203 төгрөг, ҮЭТатварт 7,405 төгрөг бүгд 139,768 төгрөг суутгаж, гарт 600,754 төгрөгийн цалин бодсоныг эрхлэгч Б.Мягмарцэнд хүлээн зөвшөөрч гарын үсэг зурж баталгаажуулсан, ХААН банкны гарт олгох тооцооны хүснэгтэд банкны нэр, дансны дугаар тавилгүй Ч.Ганболд нэрээр 600,754 төгрөгийг 2019 оны 07 сарын 16-ны 00160 дугаар төлбөрийн хүсэлтээр төрийн сангийн гүйлгээ хийсэн.

7 сарын цалин болох 600,754 төгрөг Ч.Ганболдын ХААН банкны 5286052682 дугаар дансанд 2019 оны 07 сарын 16-нд орсон байна.

- Цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 08 сарын 01-ний Б/19 дугаар тушаалаар сахиул Б.Хатанбаатарын ээлжийн амралттай байх хугацаанд **3.Ууганбаатарыг** салбар цэцэрлэгийн сахиулаар томилж, ТҮ-1-4 дэх шатлал 396,798 төгрөгөөр цалинжуулахаар шийдвэрлэсэн байна.

08 сард ажиллах өдөр 23, ажилласан өдөр 18, нийт бодогдох цалин 310,538 /396,798/23*18/ төгрөг, илүү цагийн хөлсөнд 207,025 төгрөг /396,798/18*64 илүү ажилласан цаг*1.5/ нийт олгох 517,563 төгрөгөөс ЭМДШимтгэлд 56,932 төгрөг, ХХОАТатварт 32,730 төгрөг, ҮЭТатварт 5,176 төгрөг бүгд 94,838 төгрөг суутгаж, гарт 422,725 төгрөгийн цалин бодож, 3.Ууганбаатарын ХААН банкны 5270230619 дугаар дансанд шилжүүлсэн байна. (цалин олгох хүснэгтэд гарын үсэг зурсан.)

Уг сарын ажлын цаг ашиглалтын бүртгэлд сахиулаар ажилласан гэх 3.Ууганбаатарын нэр байхгүй, 3.Ууганбаатарыг 23 өдөр ажиллахаас 18 өдөр ажилласанаар ажлын цагийн тооцоог нярав гаргасан ба эрхлэгч нягтлан бодогч нар хянаж шалган гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан байна.

Мөн цэцэрлэгийн эрхлэгчийн 2019 оны 02 сарын 01-ний Б/2 дугаар тушаалаар **3.Ууганбаатарыг** галч харуулын албан тушаалд ажиллуулахаар 2019 оны 02 сарын 01-ээс түр томилж, ТҮ-1-5 дахь шатлалын үндсэн цалин 484,635 төгрөгөөр цалинжуулахаар шийдвэрлэсэн байна.

3.Ууганбаатар нь тус долдугаар цэцэрлэгийн захиргаанд 2019 оны 01 сарын 28-нд харуулаар ажиллахыг хүсч, 2019 оны 02 сарын 25-нд харуул галчийн ажлаас чөлөөлж өгөхийг хүсч тус тус өргөдөл гаргасан байна.

02 сард ажилласан өдөр 17, үндсэн цалин 484,635 төгрөг, илүү цагийн хөлсөнд 470,381 /484635/136*88 илүү ажилласан цаг*1.5/ нийт олгох 955,016 төгрөгөөс ЭМДШимтгэлд 109,827 төгрөг, ХХОАТатварт 66,186 төгрөг, ҮЭТатварт 9,550 төгрөг, хуримтлалд 12,000 төгрөг бүгд 197,563 төгрөг суутгаж, гарт 757,453 төгрөгийн цалин бодож, шилжүүлсэн байна. Гэхдээ гарт олгох хүснэгтэд ХААН банкны нэртэй, дансны дугаар байхгүй. (цалин олгох хүснэгтэд гарын үсэг зурагдаагүй.)

Уг сард 3.Ууганбаатарыг 17 өдөр ажиллахаас 17 өдөр ажилласан гэж ажлын цагийн тооцоог нярав гаргасан ба эрхлэгч нягтлан бодогч нар хянаж шалган гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан байна. 2019 оны 02 сараас хойших ажлын цаг ашиглалтын бүртгэлийг хэн бүртгэсэн нь тодорхойгүй, “Ууган” гэж 03 сараас хойш ажиллаагүй хүний нэрээр бүртгэсэн, 2018 оны 08 сарын цалин олгох хүснэгтэд зурагдсан гарын үсэг, 2019 оны 01 сарын 28, 02 сарын 25-нд гаргасан өргөдлийн бичвэр, 2019 оны 02 сараас хойших ажлын цаг ашиглалтын бүртгэл дэх гарын үсэг зэрэг нь хоорондоо ондоо, өөр.

Салбар цэцэрлэгт галч харуулаар ажилласан гэх З.Ууганбаатар нь 2019 оны 03 сарын 01-ээс хойш огт ажиллаагүй байна.

З.Ууганбаатарын нэр дээр 2019 оны 03, 04, 05, 06 саруудад нийт бодогдсон цалин 1,938,540 /484635*4/ төгрөг, илүү цагийн хөлс 1,280,499 /484635/сар бүрийн ажиллах цаг*01-06 сард ажилласан илүү цаг 296*1.5/ төгрөг, 1-р улирлын үр дүнгийн урамшуулал 135,698 /484635*28%/ төгрөг төгрөг нийт олгох 3,354,737 төгрөгөөс ЭМНДШимтгэлд 385,796 төгрөг, ХХОАТатварт 223,562 төгрөг, ҮЭТатварт 33,547 төгрөг, хуримтлалд 48,000 төгрөг, БСУГазрын жаран жилийн ойн хандивт 21,071 төгрөг бүгд 711,976 төгрөг суутгаж, гарт олгохоор 2,642,760 төгрөгийн цалин бодож, З.Ууганбаатарын ХААН банкны 5270230619 дугаар дансанд шилжүүлж, олгосон.

Нярав Д.Жавзандулам 2019 оны 06 сарын 28-ны өдөр гаргасан “Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан”-даа сахиул З.Ууганбаатараас 03 сарын 28-нд 701,959 төгрөг, 04 сарын 28 (ням гараг)-нд 702,133 төгрөг, 05 сарын 27-нд 586,367 төгрөг, 06 сарын 14-нд 652,301 төгрөг нийт 2,642,760 төгрөгийн цалинг бэлнээр авч, байгууллагадаа бараа материал авсанаар тайлагнасан байна.

- Эрхлэгчийн 2018 оны 07 сарын 25-ны өдрийн Б/17 дугаар тушаалаар сахиул Р.Баттулгыг 08 сарын 01-ээс чөлөөлж, 2018 оны 08 сарын 01-ний өдрийн Б/19 дугаар тушаалаар **Л.Баттүвшинг** сахиулаар түр томилж, ТҮ-1-4 шатлалын 396,798 төгрөгөөр цалинжуулахаар шийдвэрлэсэн байна.

08 сард ажилласан өдөр 23, ТҮБД-1-4 шатлалын үндсэн цалин 396,798 төгрөг, илүү цагийн хөлсөнд 207,025 төгрөг /396,798/184*64 илүү ажилласан цаг*1.5/ нийт олгох 603,823 төгрөгөөс ЭМДШимтгэлд 66,421 төгрөг, ХХОАТатварт 42,073 төгрөг, ҮЭТатварт 6,038 төгрөг бүгд 114,532 төгрөг суутгаж, гарт 489,291 төгрөгийн цалин бодож, шилжүүлсэн байна. Гэхдээ гарт олгох хүснэгтэд ХААН банкны нэртэй, дансны дугаар баайхгүй, банкнаас уг сарын хүснэгт гаргуулаагүй.

Нягтлан бодогч Б.Эрдэнэчимэг сахиулаар ажилласан гэх Л.Баттүвшинг 08 сарын 01-ээс 08 сарын 31-ний өдөр хүртэл 24 цагаар ажилласан гэж нөхөж бүртгэсэн, Л.Баттүвшин нь цалин олгох хүснэгтэд гарын үсэг зураагүй байна.

Л.Баттүвшинг 23 өдөр ажиллахаас 23 өдөр ажилласан гэж ажлын цагийн тооцоог нярав гаргасан ба эрхлэгч, нягтлан бодогч нар хянаж шалган гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан байна.

- Эрхлэгчийн 2018 оны 11 сарын 22-ны өдрийн Б/32 дугаар тушаалаар **Г.Наранцацралтыг** салбар цэцэрлэгийн туслах багшаар Б.Нандин-Эрдэний (чөлөөлөгдсөн) оронд 11 сарын 27-ны өдрөөс томилон ажиллуулжээ.

Туслах багш Г.Наранцацралт нь цэцэрлэгийн захиргаанд 2019 оны 06 сарын 14-нд “хүүгээ эмнэлэгт үзүүлэх, шинжилгээ өгөх, гэрээр асрах заайлшгүй шаардлагатай гэж 06 сарын 14-ний өдрөөс 06 сарын 16-ны өдрийг хүртэл 3 өдрийн чөлөө олгох”-ыг, 2019 оны 06 сарын 24-нд “өөрийн бие өвдөж УБ хот орж шинжилгээ өгөх болсон гэж 06 сарын 24-өөс 06 сарын 27-ны өдрийг хүртэл чөлөө олгох”-ыг хүсч өргөдөл гаргасан байна.

Уг чөлөө олгохыг хүссэн өргөдөлд эрхлэгч цохолт хийгээгүй, өргөдлийн бүртэлд бүртгэдэггүй, хөдөлмөрийн дотоод журамд заасан чөлөө олгох хуудас хөтлөөгүй, эрхлэгч цалинтай, цалингүй алин болохыг цохоогүй байхад цалинтай чөлөө авсанаар цалин бодсон, цагийн бүртгэлд дээрх өдрүүдийг “ажилласнаар”, бусад өдрүүдийг 9⁰⁰-18⁰⁰ гэж бүртгэсэн хэн бүртгэсэн эсэх нь тодорхойгүй, цаг бүртгэгчийн гарын үсэгт ажиллаагүй иргэн “Ууган” гэж бичсэн.

Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2016 оны 10 сарын 20-ны өдрийн 36 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 2.10-д /.....Ажилтанд чөлөө олгохдоо байгууллагын чөлөө олгох тухай хуудсаар ажилтны хүсэлт гаргасан өргөдлийг үндэслэн олгоно./, 4.5-д /багш, ажилтанд жилд 2 удаа 3 хоногийн цалинтай чөлөө олгоно. Чөлөө олгох бүртгэлийн дэвтэрт бүртгэн тэмдэглэл хийнэ./, 4.9-д /Багш ажилтанг жилд нэг удаа цалинтай чөлөө олгон шинжилгээ болон эмчилгээнд хамруулах/ гэж тусгасан ч чөлөө олгох бүртгэлийн дэвтэр гэж шалгалтын явцад ирүүлээгүй.

Туслах багш Г.Наранцацралтад 2019 оны 06 сард ажилласан өдөр 20 үндсэн цалин 547,974 төгрөг, орон нутгийн нэмэгдэл 43,838 /547974*8%/ төгрөг, илүү цагийн хөлс 35,961 /547974/160*7*1.5/ төгрөг, амралт эдлэх хоног 20, амралтын олговорт 636,051 төгрөг нийт олгох 1,263,824 төгрөгөөс ЭМНДШимтгэлд 145,340 төгрөг, ХХОАТатварт 95,181 төгрөг, ҮЭТатварт 12,638 төгрөг, хуримтлалд 12,000 төгрөг, БСУГазрын жаран жилийн ойн хандивт 23,825 төгрөг бүгд 288,984 төгрөг суутгаж, гарт 974,840 төгрөгийн цалин бодож, Хаан банкны хувийн харилцах 5270343883 дугаар дансанд шилжүүлсэн байна.

- Туслах багш Ш.Наранцацралт нь 2017 он, 2018 оны 04 сарыг дуустал дунд бүлгийн туслах багшаар ажиллаж байгаад 2018 оны 05 сарын 02-оос 16, 05 сарын 21-ээс 30-ны өдрүүдэд ажлын 19 өдөр өвчтэй ба ХЧТАТэтгэмжид 453,256 төгрөг авсан.

2018 оны 06 сарын 04-өөс 07 сарын 09-ний өдрийг хүртэлх хугацаанд ажиллаагүй буюу ажлын цаг ашиглалтын бүртгэлд нэр нь байхгүй байна.

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 06 сарын 20-ны А/16 дугаар тушаалаар багш, ажиллагсдын 2018 оны ээлжийн амралтын хуваарийг баталсан ба үүнээс туслах багш Ш.Наранцацралтын тус онд эдлэх ээлжийн амралтыг 07 сарын 09-өөс 08 сарын 22-ныг хүртэл ажлын 27 өдрөөр эдлүүлэхээр баталж, амралтын олговорт 838,144 төгрөг олгосон байна.

Ш.Наранцацралтад 2018 оны 08 сард 8 өдөр, 09-12 сард бүтэн ажилласанаар нийт бодогдох цалин 2,189,699 төгрөг, орон нутгийн нэмэгдэл 175,176 төгрөг, илүү цагаар нийт 84 цаг ажилласан гэж илүү цагийн хөлсөнд 379,975 төгрөг, 3-р улиралд 25%, 4-р улиралд 37%-ийн үр дүнгийн урамшуулал 314,112 төгрөг, цалингийн нэмэгдэл 123,294 төгрөг нийт олгох 3,182,256 төгрөгөөс ЭМНДШимтгэлд 280,039 төгрөг, ХХОАТатварт 58,036 төгрөг, ҮЭТатварт 28,681 төгрөг, хуримтлалд 48,000 төгрөг, цалингийн урьдчилгаанд 350,000 төгрөг, бусад суутгал 3,600 төгрөг бүгд 768,356 төгрөг суутгаж, гарт 2,413,902 төгрөгийн цалин бодож, хувийн харилцах дансанд нь шилжүүлсэн байна.

08 сарын ажлын цаг ашиглалтын бүртгэлд нэр нь байхгүй, 09-12 сард харуул Цэрэнтогтох, Ж.Лундаа нар бүртгэсэн, 09 сард цаг бүртгэгч нар гарын үсэг зураагүй

(09 сарын 01,3,4,5,6-ны өдрүүдийн ажилдаа ирсэн, явсан цаг бүртгэлтэй ч өвчтэйгээр давхар бүртгэсэн), Ш.Наранцацралт 12 сарын 11-ны өдрөөс 12 сарын 14-ний өдөр хүртэлх ажлын 4 өдөрт ирсэн, явсан цаг байхгүй, цэг тавиад орхисон, 12 сарын 31-ний өдөр ажилдаа ирсэн цаг бүртгээд явсан, завсарласан, завсарлаад ирсэн цаг байхгүй.

Ш.Наранцацралтыг 08 сард 23 өдөр ажиллахаас 15 өдөр ээлжийн амралттай, 8 өдөр ажилласан гэж ажлын цагийн тооцоог нярав гаргасан, эрхлэгч, нягтлан бодогч нар хянаж шалган гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан байна.

Шалгалтын явцад туслах багш Ш.Наранцацралтын оролцож, ажиллаж байсан гэх дараах удирдамж, зургуудыг ирүүлсэн. Үүнд:

- Бүлгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулагдах “Найрал дуу-2018” урлагийн наадам 2018 оны 10 сарын 25-нд болох удирдамжтай. Энд оролцож байсан зургийг ирүүлсэн. /Зургийг хавсаргав./
- Бүлгүүдийн дунд зохион байгуулагдах “Алтан намар” өглөөлөг өдөрлөг 2018 оны 10 сарын 22-26-нд болох удирдамжтай. Зураг байгаа ч огноогүй.
- Ш.Наранцацралт багш 2018 оны 10 сарын 01, 2018 оны 10 сарын 02-нд ангийн хүүхдүүдтэйгээ хамт байгаа зураг.
- Ахлах бүлгийн хүүхдүүдийн ам зайлалтын тэмдэглэл 2018 оны 11 сар гэсэн хуулбарласан материал ирүүлсэн ч албажуулаагүй баримт байна.
- 2018 оны 11 сарын 06 туслах багш нар хичээл заасан гэсэн зураг доор нь огноог тэмдэглэсэн байна.

• Тус цэцэрлэгийн дунд бүлгийн туслах багшаар ажиллаж байсан Ш.Наранцацралт нь 2019 оны 01 сараас хойш огт ажиллаагүй байхад түүний нэр дээр цалин бодож, авсан байна. Үүнд:

2019 оны 01-06 сард нийт бодогдсон цалин 3,685,656 /614,276*6/ төгрөг, орон нутгийн нэмэгдэл 294,852 /614276*8%*6 сар/ төгрөг, илүү цагийн хөлс 487,130 /614276/сар бүрийн ажиллах цаг*01-06 сард ажилласан илүү цаг 89*1.5/ төгрөг, 1-р улирлын үр дүнгийн урамшуулал 307,138 /614276*50%/ төгрөг нийт олгох 4,774,776 төгрөгөөс ЭМНДШимтгэлд 444,054 төгрөг, ҮЭТатварт 47,748 төгрөг, хуримтлалд 72,000 төгрөг, БСУГазрын жаран жилийн ойн хандивт 26,708 төгрөг бүгд 590,510 төгрөг суутгаж, гарт 4,184,266 төгрөгийн цалин бодсон.

Мөн 2019 онд эдлэх ээлжийн амралтын олговрыг тооцохдоо 2018 оны 09-12 сар, ажиллаагүй хугацааны буюу 2019 оны 01-05 сарын хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого 7,077,083 төгрөг, нийт ажилласан хоног 189, нэг өдөрт ноогдох цалин 37,091.63 ($7077083/189=37445$ төгрөг байхыг буруу тооцсон) төгрөг, амралтын хоногийг бүтэн ажилласнаар буюу 30 хоногоор бодож амралтын цалин 1,112,748 төгрөгөөс ЭМНДШимтгэлд 103,486 төгрөг, ҮЭТатварт 11,127 төгрөг бүгд 114,613 төгрөг суутгаж, гарт 998,135 төгрөгийн амралтын олговор бодож, үүнээс Ш.Наранцацралтын 2018 оны 9-12 сарын хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого 3,006,037 төгрөг, нийт ажилласан хоног 85, нэг өдөрт ноогдох цалин 35,365 төгрөг, амралт эдлэх хоногийг 12 хоногоор тооцон амралтын цалин 424,381 төгрөгөөс 424,000 төгрөгийг няраваар дамжуулан бэлнээр олгосон байна.

01 сарын цалин 647,042 төгрөгийг Ш.Наранцацралтын ХААН банкны 5270405058 дугаар дансаар олгосон, үүнээс 647,000 төгрөгийг 01 сарын 28-нд нярав Д.Жавзандуламын ХААН банкны 5270405014 дугаар дансанд шилжүүлсэн, 02-06 сарын 4,535,359 төгрөгийн цалинг Ш.Наранцацралтын дансанд бус нярав Д.Жавзандуламын ХААН банкны 5270405014 дугаар дансаар дамжуулан шилжүүлж, авсан байна.

Ш.Наранцацралтын 2019 оны 01 сарын 28-нд орсон 01 сарын цалингийн 647,000 төгрөгийн орлого, үүнээс Э.Эрдэнэсүвдад цалингийн зөрүүд 251,000 төгрөг олгосон мөртөл бэлэн мөнгөний гүйлгээний тайланд тусгаагүй, цалингийн 647,000 төгрөгийн зарцуулалтын үндсэн баримт байхгүй байна.

Нярав Д.Жавзандулам нь 2019 оны 06 сарын 28-нд гаргасан “Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан”-д Ш.Наранцацралтаас 02 сараас 06 сарын цалинд 4,535,359 төгрөг авч үүнээс Э.Эрдэнэсүвдад туслах багшаар ажилласан цалингийн зөрүү гэж 02 сараас 06 сард нийт 1,335,400 төгрөгийг өгсөн, Ш.Наранцацралтын амралтын мөнгө 424,000 төгрөгийг Ш.Наранцацралтын дүү Ш.Наранлхагвад өгч, үлдэгдэл 2,775,959 төгрөгийг бараа материалд зарцуулсан гэж тайлагнасан байна.

- Цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 02 сарын 19-ны өдрийн Б/4 дугаар тушаалаар гал тогооны туслах ажилтаны албан тушаалд **Э.Эрдэнэсүвдыг** 02 сарын 19-өөс томилон 2018 оны 04 сарыг дуустал ажиллуулсан.

2018 оны 05 сард дунд бүлгийн туслах багш Ш.Наранцацралтыг өвчтэй байх хугацаанд Э.Эрдэнэсүвдыг гал тогооны туслах ажилтанаас чөлөөлсөн шийдвэр гаргаагүй эрхлэгчийн 2018 оны 05 сарын 01-ний Б/10 дугаар тушаалаар бүлгийн туслах багшаар томилон ТҮБД-1-1 шатлалын үндсэн цалин 416,521 төгрөгөөр цалинжуулахаар шийдвэрлэж, 05 сарыг дуустал ажиллуулсан ба 2018 оны 07 сарын 06-ны Б/15 дугаар тушаалаар туслах багшийн албан тушаалаас 07 сарын 09-ний өдрөөс чөлөөлж, уг өдрөөс гал тогоонд туслах ажилтанаар 2018 оны 07 сарын 06-ны Б/16 дугаар тушаалаар томилж ажиллуулсан байна.

Э.Эрдэнэсүвдад 2018 оны 06, 07 сард олгосон цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал:

- 06 сард туслах багшийн ТҮБД-1-1 шатлалын үндсэн цалин 416,521 төгрөг, орон нутгийн нэмэгдэл 33,322 /416,521*8%/ төгрөг нийт олгох 449,843 төгрөгөөс ЭМДШимтгэлд 49,483 төгрөг, ХХОАТатварт 26,703 төгрөг, ҮЭТатварт 4,498 төгрөг, хуримтлалд 12,000 төгрөг бүгд 92,684 төгрөг суутгаж, гарт 357,159 төгрөгийн цалин, 2-р улирлын үр дүнгийн урамшуулалд үндсэн цалингийн 41%-иар тооцон 170,774 /416,521*41%/ төгрөг олгохоос ЭМДШимтгэлд 18,785 төгрөг, ХХОАТатварт 16,865 төгрөг, аймгийн 80 жилийн ойн хандивт 16,131 төгрөг бүгд 51,781 төгрөг суутгаж, гарт 118,993 төгрөгийн урамшуулалт цалин тус тус бодож олгосон.

- 07 сард туслах багшийн үндсэн цалин 416,521 төгрөгөөс ЭМДШимтгэлд 45,817 төгрөг, ХХОАТатварт 37,070 төгрөг, ҮЭТатварт 4,165 төгрөг бүгд 87,053 төгрөг суутгаж, гарт 329,468 төгрөгийн цалин олгосон байна.

- Эрхлэгчийн 2018 оны 05 сарын 01-ний Б/09 дугаар тушаалаар гал тогооны туслах ажилтанаар Г.Уянгыг түр томилж, 2018 оны 07 сарын 06-ны Б/14 дугаар

тушаалаар 07 сарын 09-өөс чөлөөлсөн байна. Г.Уянгад 05 сард 23 өдөр, 06 сард 20 өдөр, 07 сард 7 өдрийн цалин тус тус бодож, олгосон байна.

Г.Уянгыг 2018 оны 07 сарын 09-өөс чөлөөлсөн, 07 сарын 01-ээс 09-ний өдөр хүртэл ажиллаагүй, нягтлан бодогч Б.Эрдэнэчимэг 07 сарын 19-өөс 27-ны өдрүүдэд ажлын 7 өдөр ажилласнаар нөхөж бүртгэн ажлын 7 өдрийн цалин бодож олгожээ.

Г.Уянгад 2018 оны 06, 07 сард олгосон цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал:

- 06 сард гал тогооны туслах ажилтан ТҮ-1-1 шатлалын үндсэн цалин 371,016 төгрөгөөс ЭМДШимтгэлд 40,812 төгрөг, ХХОАТатварт 19,687 төгрөг, ҮЭТатварт 3,710 төгрөг бүгд 64,209 төгрөг суутгаж, гарт 306,807 төгрөгийн цалин, 2-р улирлын үр дүнгийн урамшуулалд үндсэн цалингийн 28%-иар тооцон $103,884 / 371,016 * 28\%$ төгрөг олгохоос ЭМДШимтгэлд 11,427 төгрөг, ХХОАТатварт 9,246 төгрөг бүгд 20,673 төгрөг суутгаж, гарт 83,211 төгрөгийн урамшуулалт цалин тус тус бодож, тус тус ХААН банкны хувийн харилцах 5270400322 дугаар дансанд шилжүүлсэн байна.

- 07 сард гал тогооны туслах ажилтанаар 7 өдөр ажилласан гэж бодогдох цалин 136,690 $/ 371,016 / 19 * 7 /$ төгрөг олгохоос ЭМДШимтгэлд 15,036 төгрөг, ҮЭТатварт 1,367 төгрөг бүгд 16,403 төгрөг суутгаж, гарт 120,287 төгрөгийн цалин бодож, хувийн харилцах дээрх дансанд шилжүүлж, олгосон байна.

Мөн Э.Эрдэнэсүвдыг туслах багшийн албан тушаалд томилсон шийдвэр гаргалгүй 2019 оны 01 сараас одоог хүртэл дунд бүлгийн туслах багшаар ажиллуулсан, гал тогооны туслах ажилтаны албан тушаалд ажилласнаар цалин бодож, олгосон. Нярав туслах багшаар ажилласан цалингийн зөрүүг нягтлан бодогчоор бодуулж, туслах ажилтан Э.Эрдэнэсүвдын ХААН банкны 5270512571 дугаар хувийн харилцах дансанд шилжүүлж, олгосон байна.

Гал тогооны туслах ажилтан албан тушаалд ажилласанаар олгосон цалин хөлс, урамшуулал, амралтын олговор:

2019 оны 01 сараас 06 сард ажиллавал зохих өдрүүдэд бүтэн ажилласан ба ТҮ-1-1 дэх шатлалын үндсэн цалин 432,754 төгрөг буюу нийт бодогдох цалин 2,596,524 $/ 432,754 * 6 \text{ сар} /$ төгрөг, 1-р улирлын үр дүнгийн урамшуулал 194,739 $/ 432,754 * 45\%$ төгрөг нийт олгох 2,791,263 төгрөгөөс ЭМНДШимтгэлд 320,995 төгрөг, ХХОАТатварт 130,361 төгрөг, ҮЭТатварт 27,918 төгрөг, хуримтлалд 72,000 төгрөг, цалингийн урьдчилгаа 200,000 төгрөг, БСУГазрын 60 жилийн ойн нэг өдрийн хандивт 18,815 төгрөг бүгд 770,089 төгрөг суутгаж, гарт 2,021,174 төгрөгийн цалин, 01 сард цалингийн урьдчилгаанд 200,000 төгрөг олгож бүгд 2,221,174 төгрөгийн цалин олгосон байна.

Мөн 2019 онд эдлэх ээлжийн амралтын олговрыг тооцохдоо гал тогооны туслах ажилтаны нийт олгох цалингаас тооцсон байна. Үүнд: 2018 оны 9-12 сар, 2019 оны 01-05 сарын хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого 4,358,793 төгрөг, нийт ажилласан хоног 189, нэг өдөрт ноогдох цалин 22,844.83 $(4,358,793 / 189 = 23,062 \text{ төгрөг байхыг буруу тооцсон})$ төгрөг, амралтын хоногийг бүтэн ажилласнаар буюу 15 хоногоор бодож амралтын цалин 342,672 төгрөгөөс ЭМНДШимтгэлд 39,407 төгрөг,

ХХОАТатварт 30,326 төгрөг, ҮЭТатварт 3,427 төгрөг бүгд 73,160 төгрөг суутгаж, гарт 269,512 төгрөгийн амралтын олговор бодож, олгосон байна.

2019 оны 07 сард ажиллах өдөр 20 үүнээс ээлжийн амралтаа 07 сарын 01-ээс ажлын 15 өдөр эдэлж дуусаад, 07 сарын 25-аас ажлын 5 өдөр ажиллана гэж тооцсон ба бодогдох цалин 108,188 /432,754/20*5/ төгрөг, 2-р улирлын үр дүнгийн урамшуулал 194,739 /432754*45%/ төгрөг нийт олгох 302,927 төгрөгөөс ЭМНДШимтгэлд 34,837 төгрөг, ХХОАТатварт 6,809 төгрөг, ҮЭТатварт 1,082 төгрөг бүгд 42,728 төгрөг суутгаж, гарт 260,199 төгрөгийн цалин олгохоор тус тус бодож, Э.Эрдэнэсүвдын ХААН банкины 5270512571 дугаар дансанд шилжүүлж, олгосон байна.

Дүнд бүлгийн туслах багшаар ажиллуулсан хугацааны цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал, амралтын олговор бодсон цалингийн картыг нягтлан бодогч Б.Эрдэнэчимэг шалгалтын явцад гаргаж ирүүлсэн. Үүнд:

2019 оны 01-06 сард ТҮБД-1-5 дахь шатлалын үндсэн цалин 614,276 төгрөг буюу нийт бодогдох цалин 3,685,656 /614276*6 сар/ төгрөг, орон нутгийн нэмэгдэл 294,852 /614276*8%*6 сар/ төгрөг, илүү цагийн хөлс 487,130 /614276/сар бүрийн ажиллах цаг*01-06 сард ажилласан илүү цаг 89*1.5/ төгрөг, 1-р улирлын үр дүнгийн урамшуулал 307,138 /614276*50%/ төгрөг нийт олгох 4,774,776 төгрөгөөс ЭМНДШимтгэлд 549,099 төгрөг, ХХОАТатварт 312,571 төгрөг, ҮЭТатварт 47,748 төгрөг, хуримтлалд 72,000 төгрөг бүгд 981,418 төгрөг суутгаж, гарт 3,793,358 төгрөгийн цалин олгохоор бодсон байна.

Туслах багш Э.Эрдэнэсүвд нь байгууллагын удирдлагад туслах багшаар ажилласан хугацааны цалингийн зөрүү болох 02 сарын 26-нд 230,400 төгрөг, 03 сарын 25-нд 250,000 төгрөг, 04 сарын 23-нд 373,000 төгрөг, 05 сарын 24-нд 270,000 төгрөг, 06 сарын 17-нд 212,000 төгрөг бүгд 1,335,400 төгрөг олгож өгөхийг хүсч “Бэлэн мөнгө олгохыг хүссэн өргөдөл” гаргасан. Эрхлэгч “цалингийн зөрүүг Э.Эрдэнэсүвдад олгохыг зөвшөөрч” няравт цохсон. Нярав Д.Жавзандулам 2019 оны 06 сарын 28-нд гаргасан “бэлэн мөнгөний гүйлгээний тайлан”-д Э.Эрдэнэсүвдад 02-06 сарын цалингийн зөрүүд нийт 1,335,400 төгрөг олгосноор тусгаж, Э.Эрдэнэсүвд бүрэн хүлээн авсанаар анхан шатны баримтуудад гарын үсэг зурсан байна.

Гэвч нярав Д.Жавзандуламын ХААН банкны 5270405014 дугаар хувийн харилцах дансанаас Э.Эрдэнэсүвдын ХААН банкины 5270512571 дугаар дансанд “туслах багшаар ажилласан цалингийн зөрүүд” 01 сарын 28-нд 251,000 төгрөг, 2019 оны 02 сарын 26-нд 230,400 төгрөг, 03 сарын 25-нд 160,000 төгрөг, 04 сарын 23-нд 348,000 төгрөг, 05 сарын 24-нд 250,000 төгрөг, 06 сарын 14-нд 212,000 төгрөг бүгд 1,451,400 төгрөг шилжүүлсэн байгаа ба бэлэн мөнгөний гүйлгээний тайланд Э.Эрдэнэсүвдад 01 сард олгосон 251,000 төгрөгийг тусгаагүй, мөн Э.Эрдэнэсүвдад олгох цалингийн зөрүүгээс 03 сард 90,000 төгрөг, 04 сард 25,000 төгрөг, 05 сард 20,000 төгрөг нийт 135,000 төгрөг дутуу шилжүүлсэн. Үүнийг нярав хувийн авлагатай байсан учир суутгаж үлдэгдлийг шилжүүлсэн, Э.Эрдэнэсүвд няравт хувийн өглөгтэй байсан гэж тайлбарлаж байв.

- Нярав Д.Жавзандулам нь 2019 оны 06 сарын 28-нд гаргасан “Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан”-д 3.Ууганбаатараас 2019 оны 03 сараас 06 сарын цалин 2,642,760 төгрөг, Ш.Наранцацралтаас 2019 оны 02 сараас 06 сарын цалин 4,535,359 төгрөг нийт 7,178,119 төгрөгийн цалингийн орлого орсон, үүнээс Э.Эрдэнэсүвдад туслах багшаар ажилласан цалингийн зөрүү гэж 2019 оны 02 сараас 06 сард нийт 1,335,400 төгрөг олгосон, Ш.Наранцацралтын амралтын мөнгө 424,000 төгрөгийг Ш.Наранцацралтын дүү Ш.Наранлхагвад өгсөн, үлдэгдэл 5,418,719 төгрөгийг бараа материалд зарцуулсан гэж тайлагнасан байна. /Баримтуудыг хавсаргав./

Үүний баримтуудыг үзэхэд Батзулаас 80,000 төгрөгөөр элс авсан гэх мөнгө олгохыг хүссэн өргөдөл, бэлэн мөнгөний зарлагын баримтад гарын үсэг зурагдаагүй, бэлэн мөнгөний орлогын баримтад тамга тэмдэг дарагдаагүй, тогооч Н.Гангаамаад халадны үнэнд 100,000 төгрөг өгсөн мөнгө олгохыг хүссэн өргөдөл, бэлэн мөнгөний зарлагын баримтад “тогооч Гангаамаа” гэж бичсэн, үйлчлэгч Б.Цэрэндолгорт хувцас оёулсан хөлсөнд 480,000 төгрөг, иргэн н.Отгончимэгээс шавар зуурагч машин авч ажиллуулсаны хөлсөнд 155,000 төгрөг тус тус олгосон гэх ч гэрээ байгуулаагүй, Ганзоригт кино бичлэг хийлгэсэн гэж байгаа ч үндсэн баримт байхгүй, хөлс 50,000 төгрөгийг хүлээн авсан гарын үсэггүй, сахиулаар ажиллаж байсан Р.Баттулгаас өөрийн нь шовгорыг 1,200,000 төгрөгөөр худалдан авсан худалдах, худалдан авах гэрээ байгуулаагүй, бэлнээр 1,000,000 төгрөг өгсөн атал 1,200,000 төгрөг өгсөнөөр тайланд тусгаж, бэлэн мөнгөний зарлагын баримт үйлдсэн, үлдэгдэл 200,000 төгрөгийг хэрхэн юунд зарцуулсан баримт байхгүй, иргэн Д.Даваацэрэнгээс палк 255,000 төгрөгөөр авсан зарлагын баримт тамга тэмдэггүй, Булган сумын ойн ангиас 112,000 төгрөгөөр чацарганы суулгац, Эрээн хотоос 487,219 төгрөгөөр махны машин, 8 ш махны мод, 1 ш шанага, 2 ш халбага, 1 ш хил авсан ч тайланд тусгаагүй.

Булган сумын долдугаар цэцэрлэгийн 2019 оны 05 сарын 01-ний 20 дугаар албан бичгээр Монгол Ардын Намд “Шилдэг эко орчин” бүрдүүлэх уралдааныг анги бүлгүүдийн дунд зарлаж, энэ зорилго зорилтыг хэрэгжүүлэхийн тулд бүлэг бүр зайлшгүй 3*3 харьцаатай хүлэмж, 4*10 харьцаатай туршилтын талбай, 10 ширхэг жимсний мод тарих гэх мэт ажлуудыг хийхэд санхүүгийн хэрэгцээ шаардлага байгаа тул дэмжиж ажиллах”-ыг хүсч, шаардагдах санхүүгийн тооцоог гаргасан байна. /Албан бичгийг хавсаргав./

7.6 Өглөг, авлагын талаар:

Авлагын хувьд: 2017 онд ХХОАТатварын 24.4 мянган төгрөгийн авлагыг тайлант онд барагдуулж, оны эцэст авлаагүй. 2018 онд хувь хүнээс суутгасан татвар 19.3 мянган төгрөгийг Татварын хэлтэст илүү шилжүүлсэн, төрийн сангийн харилцах данснаас Булган сумын 6-р цэцэрлэгийн дансанд 84.5 мянган төгрөгийн гүйлгээ андууран хийгдэж оны эцэст нийт 103.8 мянган төгрөгийн авлага үүсчээ.

Өглөгийн хувьд: 2017 онд урьд онд байгууллага болон иргэнээс дутуу суутгасан татварын 36.9 мянган төгрөгийг тайлант оны 05 сард барагдуулж оны эцэст өглөггүй. 2018 онд өглөггүй тайлан баланс гарсан байна.

7.7 Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:

2017 он

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж	547,061,200	8,568,500		555,629,700
2	Машин тоног төхөөрөмж	16,658,640	6,049,200	1,188,300	21,519,540
3	Тавилга, эд хогшил	14,687,844.98	2,532,324	615,749.99	16,604,418.99
4	Номын фонд	680,200			680,200
5	Бусад үндсэн хөрөнгө	23,572,600			23,572,600
	Дүн	602,660,484.98	17,150,024	1,804,049.99	618,006,458.99

Тайлант онд төсвийн хөрөнгөөр Саммит компьютер технологи ХХК-иас 1,079.4 мянган төгрөгийн нэг бүрийн үнэтэй тоос сорогч 6 ш, 219.9 мянган төгрөгөөр хивс цэвэрлэгч машин, 139.9 мянган төгрөгөөр ус буцалгагч, Гүрсоронзон ХХК-иас 540.0 мянган төгрөгөөр хөлдөөгч, Амжилтын нар ХХК-иас 299.0 мянган төгрөгөөр өлгүүр, 239.0 мянган төгрөгөөр шкаф, Чиглэл ХХК-иас 410.0 мянган төгрөгөөр халуун баригч, 260.0 мянган төгрөгөөр хоол бэлтгэх ширээ, 320.0 мянган төгрөгөөр дээжний хөргөгч, 420.0 мянган төгрөгөөр аяга таваг ариутгагч, 3,000.0 мянган төгрөгөөр хоёрдугаар хоолны тогоо, 780.0 мянган төгрөгөөр төмс цэвэрлэгч машин, 95.0 мянган төгрөгөөр битүү чанагч, 220.0 мянган төгрөгөөр жимсний шүүс шахагч нийт 8,022.2 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 1,568.5 мянган төгрөг цэцэрлэгийн гадна талын хашааг шинэчилж барьсан, Булган барилга ХХК-иар 7,000.0 мянган төгрөгөөр авто зогсоол бариулсан (үүнээс ажлын хөлсөнд 3,950.0 мянган төгрөг), ДЗОУБайгууллагаас 98.4 мянган төгрөгийн бичгийн шүүгээ, 112.5 мянган төгрөгийн дугуйтай сандал, 73.8 мянган төгрөгийн мебель шүүгээ, 274.7 мянган төгрөгийн бичгийн шкаф нийт 559.3 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр өгч, тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2017 оны 12 сарын 26-ны өдрийн 66 дугаар тушаалаар эдэлгээ дуусч, цаашид ашиглах боломжгүй болсон 1,188.3 мянган төгрөгийн хоёрдугаар хоолны цахилгаан тогоо, 15 нэр төрлийн 615.8 мянган төгрөгийн 22 ширхэг тавилга эд хогшил нийт 1,804.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө актлан, данс бүртгэлээс хасчээ.

2018 он

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж	555,629,700	192,203,456.60	380,065,730.42	367,767,426.18
2	Машин тоног төхөөрөмж	21,519,540			21,519,540
3	Тавилга, эд хогшил	16,604,418.99	515,000	874,185	16,245,233.99
4	Номын фонд	680,200		31,000	649,200
5	Бусад үндсэн	23,572,600		23,531,500	41,100

	хөрөнгө				
6	Бусад биет бус хөрөнгө /газар/		60,152,000		60,152,000
	Дүн	618,006,458.99	252,870,456.60	404,502,415.42	466,374,500.17

Тайлант онд төсвийн хөрөнгө 515.0 мянган төгрөгөөр хөлдөөгч худалдан авч, 11,802.9 мянган төгрөгөөр биеийн тамирын талбай, тоглоомын талбай, мини дром, сүүдрэвч, цэцэрлэгийн хашаа барьсан байна.

Бусад хөрөнгөд бүртгэлтэй байсан дулаан, цэвэр бохир усны шугамыг барилга байгууламжийн дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

Засгийн газрын 2016 оны 12 сарын 21-ний 193 дугаар тогтоолын дагуу эргэлтийн бус хөрөнгө болох газар, барилга байгууламжид дахин үнэлгээг хийсэн байна. Барилга байгууламжид хийсэн дахин үнэлгээгээр 2 ширхэг барилга байгууламжийн бодит үнэ цэнэ 340,953.9 мянган төгрөгөөр, 2 ширхэг инженерийн байгууламжийн бодит үнэ цэнэ 7,404.2 мянган төгрөгөөр, 9 ширхэг нийтийн эзэмшлийн байгууламжийн бодит үнэ цэнэ 19,409.2 мянган төгрөгөөр, байгууллагын эзэмшлийн 2 ширхэг 6552 м.кв газрын эзэмших эрхийн бодит үнэ цэнэ 60,152.0 мянган төгрөгөөр тус тус үнэлэгдсэн байна.

Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 12 сарын 24-ний өдрийн Б/34 дугаар тушаалаар эдэлгээ дуусч, цаашид ашиглах боломжгүй болсон 1,352.4 мянган төгрөгийн хашаа, ном, тоглоом, эд хогшлыг актлан, данс бүртгэлээс хассан байна.

7.8 Бараа материалын хөдлөл өөрчлөлт:

2017 он

№	Үзүүлэлт	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Бичиг хэрэг	24,000	2,217,500	2,182,500	59,000
2	Аж ахуй	1,141,470	2,191,280	1,757,990	1,574,760
3	Түлш шатах тослох	1,620,000	5,812,350	5,032,350	2,400,000
4	Барилгын засвар	30,000	5,691,030	5,691,030	30,000
5	Хүнс	4,262,961.10	41,684,619	40,204,174	5,743,406
6	Сэлбэг хэрэгсэл /Тоглоом/	9,499,287.40	2,834,000	1,706,030	10,627,257.40
7	ном	1,255,502			1,255,502
8	Бусад хангамж	31,879,860.11	3,708,600	6,280,780.11	29,307,680
	Дүн	49,713,080.61	64,139,379	62,854,854.21	50,997,605.40

Төсвийн хөрөнгөөр 64,139.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 55,693.4 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, цэцэрлэгийн эрхлэгчийн 2017 оны 12 сарын 26-ны өдрийн 66 дугаар тушаалыг үндэслэн бичиг хэрэг, тоглоом, бусад хангамжийн материалаас ашиглалтын шаардлага хангахгүй болсон 198 нэр төрлийн 1418 ширхэг 7,161.4 мянган төгрөгийн бараа материалыг актлан, данс бүртгэлээс хассан байна.

Тайлант онд тус цэрлэг нь бэлтгэл, ахлах, дунд, бага, холимог А, холимог Б гэсэн 6 бүлэгт 24700 хүүхэд өдөр буюу өдөрт 130 хүүхэд хамруулахаас 24244 хүүхэд өдөр буюу өдөрт 128 хүүхэд (долдугаар цэцэрлэгт нэг ангид дунджаар 25

хүүхэд, салбар цэцэрлэгт нэг ангид дунджаар 14 хүүхэд) хамрагдаж, хоолны зардалд 40,204.2 мянган төгрөг зарцуулсан байна.

2017 оны 12 сарын 18-нд иргэн Г.Болормаагаас 5500 төгрөгийн нэг бүрийн үнэтэй 209 кг 500 гр үхрийн мах 1,152,250 төгрөгөөр авч, 204 кг 590 гр махны үнэнд 1,125,245 төгрөг шилжүүлж, үлдэгдэл 4кг 910 гр махны 27,005 төгрөгийг дутуу шилжүүлсэн ч тайлан балансад өглөгөөр тусгаагүй.

Нярав Г.Болормаагаас 209.5 кг мах авч, анхан шатны баримтыг зөв үйлдэн, тайланд зөв тусгаж, оны эцэст 5500 төгрөгийн нэг бүрийн үнэтэй 673.4 кг махны үлдэгдэлтэй байхаар тайлан гаргасан байхад нягтлан бодогч оны эцэст 668 кг 490 гр мах үлдэхээр тайланг засч, нярав агуулахын бүртгэлээрх байх ёстой махны үлдэгдэл дүнг зассан. Г.Болормаа нь махны тоо ширхэгийг зөв бичсэн ч нэхэмжлэх дэх махны нийт үнийн дүн “1,152,250 төгрөг” дүгнэхийг “1,125,245 төгрөг гэж буруу дүгнэсэн, нягтлан бодогч нягтлаж сайн шалгаагүйгээс махны үнийг дутуу шилжүүлсэн байна.

2018 онд иргэн Д.Батмөнхөөс 5500 төгрөгийн үнэтэй 221.9 кг мах авч, үнэнд 1,220,450 төгрөг өгөх байсан ч уг иргэнээс 02 сарын 13-нд 20.5 кг, 02 сарын 07-нд 206.31 кг бүгд 226.81 кг мах авсанаар баримт бүрдүүлэн махны үнэнд 1,247,455 төгрөг шилжүүлж, 4кг 910 гр махны 27,005 төгрөг илүү шилжүүлсэн. Үүнийг урьд онд иргэн Г.Болормаад махны үнэнд 27,005 төгрөг өгөх өглөгийг өгсөн гэж нягтлан бодогч, нярав нар тайлбарлаж байв.

2018 он

№	Үзүүлэлт	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Бичиг хэрэг	59,000	2,471,190	2,486,190	44,000
2	Аж ахуй	1,574,760	4,175,120	2,403,210	3,346,670
3	Түлш шатах тослох	2,400,000	4,793,625	5,653,625	1,540,000
4	Барилгын засвар	30,000	6,304,200	6,334,200	0
5	Хүнс	5,743,406	33,460,490	35,367,301	3,836,595
6	Сэлбэг хэрэгсэл /Тоглоом/	10,627,257.40	16,500	4,481,020	6,162,737.40
7	Ном, бусад нөөц	1,255,502	32,000	135,300	1,152,202
8	Бусад хангамж	29,307,680	4,113,400	4,641,370	28,779,710
	Дүн	50,997,605.40	55,366,525	61,502,216	44,861,914.40

Төсвийн хөрөнгөөр 55,366.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 52,241.5 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 06 сарын 25-ны А/18, 12 сарын 24-ний Б/34 дугаар тушаалыг үндэслэн аж ахуй, тоглоом, бусад хангамжийн материалаас ашиглалтын шаардлага хангахгүй болсон 9,260.7 мянган төгрөгийн бараа материалыг акталж, данс бүртгэлээс хассан байна.

Тайлант онд тус цэрлэг нь бэлтгэл, ахлах, дунд, бага, холимог А, холимог Б гэсэн 6 бүлэгт 21450 хүүхэд өдөр буюу өдөрт 130 хүүхэд хамруулахаас 21018 хүүхэд өдөр буюу өдөрт 127 хүүхэд (долдугаар цэцэрлэгт нэг ангид дунджаар 25 хүүхэд, салбар цэцэрлэгт нэг ангид дунджаар 14 хүүхэд) хамрагдаж хоолны зардалд 35,367.3 мянган төгрөг зарцуулсан байна.

2018 оны 12 сарын 21-нд Орхон мандал ХХК-иас 6,000 төгрөгийн нэг бүрийн үнэтэй 468.7 кг үхрийн мах 2,812,200 төгрөгөөр худалдан авсанаас 366.8 кг махны 2,200,800 төгрөгийг шилжүүлж, үлдэгдэл 101.9 кг махны 611,400 төгрөгийг тайлан балансад өглөгөөр тусгалгүй 2019 оны 01 сарын 30-ны өдрийн 00004 дугаартай төлбөрийн хүсэлтээр Орхон мандал ХХК-нд шилжүүлсэн байна.

Нярав Орхон мандал ХХК-иас авсан 468.7 кг махаа бүрэн авсан ч 2018 оны 12 сарын 21-нд 366.8 кг мах авсанаар орлогын баримт үйлдэн хүнсний 12 сарын тайланд орлогодож, 2018 оны жилийн эцэст 6000 төгрөгийн үнэтэй мах 490.4 кг үлдэгдэлтэй тайлан гарах байтал 388.5 кг үлдсэнээр буруу тайлагнасан. Үлдэгдэл 101.9 кг махыг агуулахын бүртгэлд 2019 оны 01 сарын 11-нд орлогодож, 1 сарын хүнсний тайланд орлогодсон байна.

ШАЛГУУЛАГЧИЙН ОЛОЛТТОЙ БОЛОН ДЭВШИЛТТЭЙ ТАЛ

✓ Санхүүгийн тайлан, мэдээг цаг хугацаанд нь гаргаж, холбогдох байгууллагаар хянуулан баталгаажуулсан.

✓ 2017 оны 1-8 сарын цалингийн гарт олгох хүснэгтийг банкинд өгч гарын үсэг зуруулж баталгаажуулан санхүүгийн баримтад үдэж архивласан.

✓ Тооллогын комисс, Өмч хамгаалах байнгын зөвлөл нь тооллогыг хуулийн хугацаанд чанартай хийж, илтгэх хуудас, дүгнэлтдээ актлах хөрөнгө, материалын шалтгааныг тодорхой тусган, зургаар баталгаажуулсан, нягтлан бодогч тооцоог бодож акт үйлдсэн сайн талтай байна.

ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

➤ Байгууллагын удирдлага тушаал өөрөө төлөвлөн гаргаж, баталгаажуулдаг, тушаалын бүртгэлийн дэвтэр хөтөлдөггүй, зарим шийдвэрүүдийн дугаар давхардсан байна. Тухайлбал: **2017 онд** 04 сарын 05-ны Б/18 дугаартай “Үр дүнгийн урамшуулал олгох тухай”, 04 сарын 17-ны Б/18 дугаартай “Б.Нандин-Эрдэнийг ажилд түр томилох тухай” тушаалтай, 04 сарын 05-ны Б/19 дугаартай “Үр дүнгийн урамшуулал олгох тухай”, 04 сарын 21-ны Б/19 дугаар “Үр чадварын нэмэгдэл олгох тухай”, 05 сарын 08-ны Б/19 дугаартай “Б.Нандин-Эрдэнийг ажлаас чөлөөлөх тухай” тушаалууд давхар дугаартай, 09 сарын 15-ны 38 дугаар “Зөвлөл ажлын хэсэг томилох тухай”, 09 сарын 20-ны 38 дугаар “Үр чадварын нэмэгдэл олгох тухай” тушаал, 10 сарын 02-ны 42 дугаартай “Д.Алтанцэцэгийг хөгжмийн багшийн албан тушаалд томилох тухай”, 10 сарын 03-ны 42 дугаар “Үр дүнгийн урамшуулал олгох тухай” тушаалтай, 2018 онд 03 сарын 21-ний А/9 дугаар “Зэргийн нэмэгдэл олгох тухай”, 03 сарын 23-ны А/9 дугаар “Үр дүнгийн урамшуулал олгох тухай” тушаалтай тус тус давхардсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./, Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 07 сарын 07-ны өдрийн 68 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийн ажлын үндсэн заавар”-ын 2.4.1.2-д /Байгууллагын үндсэн үйл ажиллагааны болон боловсон хүчний асуудлаар тус тусад нь тушаал гаргана. Тушаалын төслийг

удирдлагын шийдвэрийн үндсэн дээр зохион байгуулалтын нэгжүүд ажил, үүргийн чиглэлийн дагуу хариуцан бэлтгэнэ./ заасан заалтыг мөрдөж ажиллаагүй.

➤ Булган сумын 7-р цэцэрлэгийн эрхлэгчийн 2017 оны 11 сарын 08-ны өдрийн 54 дугаар тушаалаар туслах багш С.Нарангэрэлд сахилгын шийтгэл ногдуулж сануулах арга хэмжээ авсан мөртөл цэцэрлэгийн эрхлэгчийн 2017 оны 12 сарын 14-ний өдрийн 61, 63 дугаар тушаалаар Улсын Их Хурлын 2017 оны 11 сарын 09-ний өдрийн 67 дугаар тогтоолыг үндэслэн сахилгын шийтгэл хүлээсэн туслах багш С.Нарангэрэлд төрийн албан хаагчид нэг удаа олгох мөнгөн урамшуулал 300.0 мянган төгрөг олгосон нь Монгол улсын Засгийн газрын 2017 оны 12 сарын 06-ны өдрийн 52 дугаар хуралдааны тэмдэглэлийг зөрчсөн.

➤ Иргэн Г.Болормаагаас **2017** оны 12 сарын 18-нд 5500 төгрөгийн нэг бүрийн үнэтэй 209.5 кг үхрийн мах 1,152,250 төгрөгөөр авч, махны үнэнд 1,125,245 төгрөг шилжүүлж, үлдэгдэл 4.910 кг махны 27,005 төгрөгийг дутуу шилжүүлсэн ч тайлан балансад өглөгөөр тусгаагүй, дараа онд нь дутуу олгосон махны үнийг иргэн Д.Батмөнхөөс худалдан авсан мэтээр баримт бүрдүүлсэн, Г.Болормаад дутуу олгосон махны 27,005 төгрөгийг олгосон гэх үндсэн баримт байхгүй, **2018** оны 12 сард Орхон мандал ХХК-иас 6,000 төгрөгийн үнэтэй 468.7 кг үхрийн мах 2,812,200 төгрөгөөр худалдан авч, махны үнэнд 2,200,800 төгрөгийг шилжүүлж, үлдэгдэл 101.9 кг махны 611,400 төгрөгийг тайлан балансад өглөгөөр тусгаагүй, нярав Орхон мандал ХХК-иас 468.7 кг мах бүрэн авсан ч тайланд 366.8 кг мах авсанаар тусган 101.9 кг мах дутуу орлогдсон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./, 14.4.3-д /Нягтлан бодох бүртгэлд..... бүх өр төлбөрийг заавал бүртгэнэ./ заасан заалтуудтай нийцэхгүй байна.

➤ Ажлын цагийн тооцоог цагийн бүртгэл үндэслэж гаргадаггүй, ажиллагсдын завсарласан, завсарлаад ирсэн цаг, минутыг бүртгэдэггүй, сахиул, харуул нар “24 цаг” эсвэл тухайн өдрийн өглөө гараад 24 цаг биш 12 цаг ажиллаад буусанаар, долоо хоногийн амралтын өдөр болон нийтээр амрах баярын өдрүүдэд гараа нь таарч ажилласан мөртөл амарсанаар бүртгэсэн байхад илүү цагийн хөлс олгосон, өвчтэй, чөлөөтэй байсан ажилтныг ажилдаа ирсэнээр, огт ажиллаагүй хүнийг ажилласанаар худал бүртгэсэн, тухай бүрд нь бүртгэхгүй нөхөж бүртгэдэг, сахиул өөрөө бүртгэсэн мэтээр бусдын нөхөж бүртгэсэн бүртгэлд гарын үсэг зурдаг, сахиул ээлжийн амралттай байсан атал бусад албан хаагчдын ажлын цагийг бүртгэсэн, ажлын цаг ашиглалтын бүртгэлийг батлагдсан маягтын дагуу бүрэн тэмдэглэж бөглөөгүй, худал, буруу бүртгэсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./, 13.5-д /Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно.../, 13.7-д /анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./, 20.1.4-д /Ерөнхий нягтлан бодогч хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх бүрэн эрхтэй./ заасан заалтууд, Сангийн сайдын 2017 оны 12 сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж

ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар” –ын 4.1-д /Ажлын цаг ашиглалтын бүртгэл НХМаягт ЦХ-1-ажлын цагийг бүртгэхдээ хүн нэг бүрийн өглөө, өдөр ажилдаа ирсэн цагийг 1, 3 мөрөнд, өдөр, орой тарсныг 2, 4 дүгээр мөрөнд, тухайн өдрийн нийт ажилласан цагийг 5 дугаар мөрөнд, илүү ажилласан цагийг ажилласан цагт оруулахгүйгээр зохих шифрээр ажилласан цагийн ард 5 дугаар мөрөнд тус тус бүртгэнэ. Сарын эцэст ажиллаагүй цагаас шалтгаантайг нь зохих шифрээр 11 дүгээр баганад нөхөж бичнэ./, 4.2-д /Ажлын цагийн тооцоо НХМаягт ЦХ-2 -ажлын цагийн тооцоог үндэслэн цалин хөлсний тооцоог хийх тул цаг бүртгэгчид тоог цэвэр нямбай, засваргүйгээр нөхөн бичсэн байх шаардлагатай. Хариуцсан нягтлан бодогч ажлын цагийн тооцоог ажлын цаг ашиглалтын бүртгэлтэй хүн нэг бүрээр тулган шалгаж хүлээн авсаны эцэст, дараагийн шатны цаг ашиглалтын бүртгэлийг олгоно./ заасан нөхөх заавруудыг тус тус зөрчсөн.

➤ Нягтлан бодогч Д.Баярчимэг, Б.Эрдэнэчимэг нар бүртгэлийн данс болон нэмэлт санхүүжилтийн данснаас “ногоон гэрэл цагаан шугам”-ын 180.0 мянган төгрөг, “Оны тэргүүний ажилтан”-ны шагналын 90.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж ачуулсан тээврийн хөлс 150.0 мянган төгрөгийг багш, ажиллагсдын хуримтлалын дансанд, багш Н.Энхээгийн томилолтын зардал 32.0 мянган төгрөгийг ахмадын сангийн дансанд тус тус шилжүүлсэн ч бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./, Сангийн сайдын 2000 оны 69 дугаар тушаалаар батлагдсан “Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм”-ийн 2.10-д /Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид гарган өгч байх үүрэгтэй./, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам” 3.1-д /Төсөвт байгууллага нь Төрийн сангийн бүртгэлийн данснаас байгууллагын төлбөрийн картын дансаар дамжуулан бэлэн мөнгийг байгууллагын касст хүлээн авч зориулалтын дагуу зарцуулах үүргийг хүлээнэ./, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан нөхөх зааврын 2.3-д /Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан НХМаягт МХ-4.....Мөнгөний нярав орлого, зарлагын баримтууд, мөнгө олгохыг хүссэн өргөдөл зэргийг үндэслэн баримт тус бүрээр өдөр бүр бэлэн мөнгөн гүйлгээний тайланг 2 хувь үйлдэн, 1 хувийг холбогдох баримтуудын хамт нягтлан бодогчид тушааж, үлдэх хувийг өөртөө үлдээнэ. Нягтлан бодогч бэлэн мөнгөн гүйлгээний тайлангийн хуудсыг нь хосоор ижил дугаарлаж няравт өгөх бөгөөд тэрхүү дугаарын тоо санхүүгийн жилд тасралтгүй мөрдөгдөж байвал зохино. / заасан заалтуудыг зөрчсөн байна.

➤ Ахмадын сангийн хөрөнгийн баримтуудын эмх цэгц муу, бэлэн мөнгө, бараа материалын тайлан гаргаагүй, тавин олголтын баримт зарим зарцуулалтад үйлдээгүй, ахмадын сангийн хөрөнгийг хамт олондоо жил бүр тайлагнаагүй төдийгүй **2018** онд ахмадын сангийн хөрөнгөөс сар шинийн баяраар 10 ахмад настанд хүндэтгэл үзүүлэхэд 250.0 мянган төгрөг, ахмадуудын “Дуун цэнгүүн” зохион байгуулахад 14.5 мянган төгрөг, тус цэцэрлэгээс өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настан Ч.Наранчимэгт олгосон мөнгөн аяга, дурсгалын зүйлд 200.0 мянган төгрөг бүгд 464.5 мянган төгрөгийг байгууллагын даргын зарцуулахыг

зөвшөөрсөн шийдвэргүй байхад тавин олгож, зарцуулсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7 дахь, Засгийн газрын 2017 оны 07 сарын 04-ний 197 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 4.3 дахь /Байгууллагын захиргаа нь сангийн орлого, зарлагын жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор гаргаж, байгууллагын дэргэдэхзөвлөлд тайлагнана./ заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй.

➤ Санхүүгийн хяналт аудитын албанаас Булган сумын төрийн санд тус цэцэрлэгийн 2019 оны 07 сарын цалингийн гүйлгээ хийхээс нь өмнө “ажиллаагүй хүнд цалин бодогдох эрсдэлтэй” талаар нягталж сайн хянаж гүйлгээ хийхийг сануулсан ч 2019 оны 07 сард тус цэцэрлэгт харуулын албан тушаалд ажиллаагүй Ч.Ганболд гэх иргэний нэр дээр бодогдсон 600,754 төгрөгийн цалингийн гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./, Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.4-д /Төрийн сан Төлбөрийн хүсэлт, холбогдох баримт нь шаардлага хангаагүй, тохиолдолд гүйлгээг буцаана./ заасан заалтуудыг зөрчсөн.

➤ Эрхлэгчийн 2018 оны 07 сарын 31-ний Б/18 дугаар тушаалаар багш Д.Болормаад хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг дахин зөрчсөн гэж 08 сарын 01-ээс 3 сарын хугацаатай үндсэн цалинг 20%-иар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан байна. Гэвч багш Д.Болормаад 2018 оны 06 сарын 18-аас ээлжийн амралтыг эдлүүлсэн, байгууллагын удирдлага багш Д.Болормаад уг шийдвэрийг биелүүлэх тухай мэдэгдэх хуудас хүргүүлээгүй байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн 83 дугаар зүйлийн 83.1.4-д /үүрэг хүлээгчид 14 буюу түүнээс доошгүй хоногийн хугацаанд захиргааны шийдвэрийг биелүүлэх тухай мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн байх/ заасан заалтыг хэрэгжүүлээгүй байна.

➤ Дунд бүлгийн туслах багш Ш.Наранцацралтыг 2018 оны 05 сард өвчтэй байхад гал тогооны туслах ажилтан Э.Эрдэнэсүвдыг томилж ажиллуулсан. Гэвч хичээлийн жил дуусч хүүхэд тарсан, орон тооны үндсэн ажилтан болох туслах багш Ш.Наранцацралтыг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн, халсан шийдвэр байхгүй байхад Э.Эрдэнэсүвдыг туслах багшаас чөлөөлөлгүй 2018 оны 06 сарын 04-өөс 07 сарын 09-ний өдрийг хүртэл хугацаанд туслах багшаар ажиллуулсан ба дээрх хугацаанд тус цэцэрлэгийн дунд бүлгийн туслах багшийн албан тушаалд “ХОЁР” албан хаагчийн орон тоотой ажилласан байгаа нь Төсвийн тухай хуулийн 16.5.3-д /Төсвийн шууд захирагч нь батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./ заасан заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

➤ Нярав Д.Жавзандулам нь туслах багшаар ажиллаж байсан Ш.Наранцацралтын нэр дээр гаргасан 2019 оны 01 сарын цалингийн 647,000 төгрөг, дуу хөгжмийн багш Алтанцэцэгээс 2019 оны 04, 05 сард няравын дансанд

буцаан шилжүүлсэн ур чадварын нэмэгдэл цалингийн 300,900 төгрөг, туслах багш Ш.Оюунчимэгийн нэр дээр 2018 оны 12 сард ур чадварын нэмэгдэл бичиж олгоод буцаан хуримтлалын дансанаас авсан ур чадварын нэмэгдэл цалингийн 100,000 төгрөг, багш Д.Болормаагаас 2018 оны 07 сард няравын дансанд буцаан шилжүүлсэн улирлын ажлын үр дүнгийн урамшууллын 220,000 төгрөг нийт 1,267,900 төгрөгийн орлого, Ш.Наранцацралтын нэр дээр гаргасан 2019 оны 01 сарын цалингаас туслах багшаар ажилласан Э.Эрдэнэсүвдад олгосон цалингийн зөрүү 251,000 төгрөгийн зарлагад бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй, цалингийн 647,000 төгрөгийн зарцуулалтын үндсэн баримт байхгүй, сахиулаар ажиллаж байсан Р.Баттулгаас шовгор худалдан авч 1,000,000 төгрөг бэлнээр өгсөн атал 1,200,000 төгрөг өгсөнөөр бэлэн мөнгөний зарлагын баримт үйлдэж, тайланд тусгасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./, 13.7-д /анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./, Сангийн сайдын 2000 оны 69 дугаар тушаалаар батлагдсан “Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм”-ийн 2.10-д /Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид гарган өгч байх үүрэгтэй./, 3.6-д /Эд хариуцагч хөрөнгийн ашиглалтын талаар тогтоогдсон хууль дүрэм зөрчсөн, өмч хөрөнгө үрэгдэж шамшигдахад хүргэж болох шийдвэр, ажил явууллагыг хүлээн авах буюу биелүүлэхээс татгалзах буюу энэ тухай өөрийн байгууллагын удирдлага, зохих албан тушаалтанд мэдэгдэх эрхтэй./, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан нөхөх зааврын 2.3-д /Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан НХМаягт МХ-4.....Мөнгөний нярав орлого, зарлагын баримтууд, мөнгө олгохыг хүссэн өргөдөл зэргийг үндэслэн баримт тус бүрээр өдөр бүр бэлэн мөнгөн гүйлгээний тайланг 2 хувь үйлдэн, 1 хувийг холбогдох баримтуудын хамт нягтлан бодогчид тушааж, үлдэх хувийг өөртөө үлдээнэ. Нягтлан бодогч бэлэн мөнгөн гүйлгээний тайлангийн хуудсыг нь хосоор ижил дугаарлаж няравт өгөх бөгөөд тэрхүү дугаарын тоо санхүүгийн жилд тасралтгүй мөрдөгдөж байвал зохино. / заасан заалтуудыг зөрчсөн.

➤ Бараа материалд агуулахын бүртгэл хөтлөөгүй, орлогын баримтыг бараа материалын данс, дансдаар хөтөлдөггүй, 2017 оны 09 сараас хойших (2018 оны 12 сарынх баримтад бий) банкны гарт олгох тооцооны хүснэгтийг санхүүгийн баримтанд үдэж архивлаагүй, илүү цагийн хөлсийг тогтмол 168 цагт ногдуулж бодсоноос 2018 оны 10 сард илүү, 11 сард дутуу олгосон, 2017 онд няравын программ 250.0 мянган төгрөгөөр суурилуулж шууд зардалд тусгасан, нэмэлт санхүүжилтийн дансаар орсон олимпиадын зардлын 168.0 мянган төгрөгөөр хүнсний материал авсан ч хэнд олгосон зарцуулалтын баримт байхгүй, мөн Хишиг-Өндөр сумаас үнэ төлбөргүй олимпиадын хоолонд өгсөн хонины махыг тайланд тусгаагүй, СӨБ-ын багш нарын сургалтын цай хоолны зардлын 897.0 мянган төгрөгөөр хүнс, бараа материал авсан ч хүнс, бараа материал авсан ч тайланд орлогодоогүй, тавьж олгосон баримт байхгүй, гарт олгох цалингийн жагсаалтыг банк тус бүрээр нь зөвхөн нэг хувь гаргаж банкуудад өгч санхүүгийн баримтад үдэж архивлаагүй, чөлөө олгохыг хүссэн өргөдөлд цохолт хийдэггүй, чөлөөний хуудас,

бүртгэл байхгүй, багш нар ирцийн бүртгэлийг засвартай үйлдсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./, Сангийн сайдын 2000 оны 69 дугаар тушаалаар батлагдсан “Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм”-ийн 2.8-д /Эд хариуцагч нь хариуцаж байгаа эд зүйлийг зохих хууль ёсны баримт материал бүрдсэн буюу удирдлагын шийдвэрээр зориулагдсан зүйлд нь өөрийн биеэр тавин олгож, хяналт тавьж ажиллах үүрэгтэй. /, 2.10-д /Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид гарган өгч байх үүрэгтэй./ заасан заалтуудыг хэрэгжүүлээгүй.

➤ 2017, 2018 онд ур чадварын нэмэгдлийг багш, туслах багш, арга зүйчид ажлын хэсгийн дүгнэлт үндэслээгүй, бусад албан хаагчид байгууллага дотооддоо боловсруулсан журамгүйгээр олгосон нь Хүн амын бодлого, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дугаар тушаалаар баталсан “Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 6-д /Энэхүү нийтлэг журмыг үндэслэн байгууллагын захиргаа нь тухайн албан хаагчид эрхэлж буй ажлын үр дүнгээр ур чадварын нэмэгдэл олгох бусад шалгуур үзүүлэлт, нэмэгдлийн хэмжээ тусгасан журмыг боловсруулан баталж мөрдүүлнэ./, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2010 оны 362/112/183 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт”-ийн 9-д /...цэцэрлэгийн багш, туслах багш, арга зүйчид ур чадварын нэмэгдэл олгох, олгож байгаа нэмэгдлийн хэмжээг нэмэгдүүлэх, бууруулах, хасах асуудлыг ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн тухайн байгууллагын ерөнхий менежерийн тушаалаар шийдвэрлэнэ./заасан заалтуудыг зөрчсөн.

➤ 2017, 2018 онд багш ажиллагсдаар улирлын ажлын тайланг үнэлүүлсэн ч хөндлөнгийн үнэлгээгээр магадлан баталгаажуулаагүй, 2017 оны 1-3-р улирлын үр дүнгийн урамшуулал олгох тушаалд шалгуурын урамшуулал тооцох хувийг биш шалгуурын биелэлтийн хувийг тавьсан байгаа нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 08 сарын 13 өдрийн А/293 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Цэцэрлэгийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам”-ын 3.2-д /Багшийн улирал бүрийн өөрийн үнэлгээг тухайн байгууллагын нийт хамт олон болон эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг магадлан баталгаажуулна...../, мөн журмын 3.6-д /Улирал бүр тухайн байгууллагын нийт хамт олон болон эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг магадлан баталгаажуулсан өөрийн үнэлгээг цэцэрлэгийн эрхлэгч тушаалаар батална./ заасан заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА,
ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

➤ Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын ахлах байцаагчийн 09 актаар 7,907,834 төгрөгийн төлбөр тогтоов. Үүнд:

- Ур чадварын нэмэгдлийн илүү олгосон 389,400 төгрөгийг төлүүлж, төсвийн орлогод төвлөрүүлэх, дутуу олгосон 80,000 төгрөгийг 2 албан хаагчид нөхөн олгох.

- Илүү олгосон шагналын дагалдах мөнгө 9,000 төгрөгийг төлүүлж, төсвийн орлого болгох.

- Үндсэн баримтгүйгээр зарцуулсан ахмадын сангийн хөрөнгө 337,000 төгрөгийг төлүүлж, төсвийн орлогод төвлөрүүлэх.

- Ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшуулалт цалин олгоод буцаан авч, зориулалт бусаар зарцуулсан 588,019 төгрөгийг төлүүлж, төлүүлж, төсвийн орлогод төвлөрүүлэх.

- 2018 оны 10 сард туслах багш Ч.Наранчимэг ажиллаагүй, оронд нь Б.Саранцэцэгийг туслах багшаар ажиллуулж, ажилласан албан хаагчид бус ажиллаагүй хүний нэр дээр цалин бодож 54,379 төгрөг илүү олгосонг төлүүлж, төсвийн орлого болгох.

- 2018 оны 06 сард тогооч бус машинист мэргэжилтэй Ч.Ганболд гэх иргэнийг гал тогоонд ажиллуулахаар тушаал гаргаж 123,844 төгрөг, 2019 оны 07 сард Ч.Ганболд гэх иргэнийг жижүүрийн албан тушаалд огт ажиллаагүй байхад “ажилласанаар” хуурамч баримт бүрдүүлэн түүний нэр дээр 600,754 төгрөг бүгд 724,598 төгрөгийн цалин бодож, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсаныг төлүүлж, төсвийн орлогод төвлөрүүлэх

- Туслах багшаар ажиллаж байсан Ш.Наранцацралтыг 2019 оны 01 сараас хойш огт ажиллаагүй байхад ажлаас чөлөөлсөн шийдвэр гаргалгүй 01-06 сард “ажилласанаар” хуурамч баримт бүрдүүлэн түүний нэр дээр 4,184,266 төгрөгийн цалин бодож, үүнээс оронд нь туслах багшаар ажилласан Э.Эрдэнэсүвдад цалингийн зөрүүд 1,586,400 төгрөгийг өгч, үлдэгдэл 2,597,866 төгрөгийг няравын дансаар дамжуулан авч, зориулалт бусаар зарцуулсаныг төлүүлж, төсвийн орлогод төвлөрүүлэх

- 3.Ууганбаатарыг салбар тавдугаар цэцэрлэгийн сахиулаар 2019 оны 03-06 сард огт ажиллаагүй байхад “ажилласанаар” хуурамч баримт бүрдүүлэн түүний нэр дээр 2,642,760 төгрөгийн цалин бодож, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсаныг төлүүлж, төсвийн орлого болгох

- Гал тогооны туслах ажилтан Э.Эрдэнэсүвдыг 2019 оны 01-06 сард Ш.Наранцацралтын оронд ажилд томилсон шийдвэр гаргалгүй туслах багшаар ажилуулж гал тогооны туслах ажилтаны албан тушаалд ажилласнаар 2,221,174 төгрөгийн цалин, туслах багшаар ажилласан цалингийн зөрүүд 1,586,400 төгрөг бүгд 3,807,754 төгрөгийн цалин, урамшуулал олгохоос 484,812 төгрөгийн цалин илүү олгосоныг төлүүлж, төсвийн орлогод төвлөрүүлэхээр улсын ахлах байцаагчийн акт тус тус тогтоов.

➤ Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 13 заалттай 1 албан шаардлага үйлдэж, мэргэжил арга зүйн зөвлөгөөг 3 албан хаагчид өгөв.

➤ 2019 оны 07 сард Ш.Наранцацралтын нэр дээр 2-р улирлын үр дүнгийн урамшуулал үндсэн цалингийн 59 хувиар 362,423 төгрөг бодож, гарт 328,718 төгрөгийн цалин, 3.Ууганбаатарын нэр дээр 07 сард 20 өдөр ажилласан, илүү цагаар 88 цаг, ур чадварын нэмэгдэл 25 хувиар, хоёрдугаар улирлын үр дүнгийн урамшуулалд 45 хувиар нийт 1,223,704 төгрөгийн цалин бодож, гарт 981,291 төгрөгийн цалин тус тус олгохоор бодсон байсныг шалгалтын явцад Булган сумын төрийн сангаас гүйлгээ хийлгүй зогсоосон.

➤ Нягтлан бодогч Б.Эрдэнэчимэгээр 2017 оны 09-12 сар, 2018 оны 01-06, 9-12 сар, 2019 оны 01-06 сарын ХААН, ХАС банкаар олгосон цалингийн гарт олгох хүснэгтийг гаргуулав.

➤ Нягтлан бодогч асан Д.Баярчимэг, Б.Эрдэнэчимэг нар 2017 оны 03 сар, 2019 оны 01 сард илүү цагийн хөлс буруу бодсоныг залруулж дараа сард нь суутган тооцсон, мөн 2018 оны жилийн эцэст ХХОАТатварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тооцоог хийж, илүү 39.7 мянган төгрөгийг суутгаж, дутуу 131.0 мянган төгрөгийг буцаан 12 сарын гарт олгох цалин дээр нэмж олгосон байна.

ДҮГНЭЛТ

✓ Тус сумын долдугаар цэцэрлэгийн туслах багшаар ажиллаж байсан Ш.Наранцацралт нь 2019 оны 01 сараас 06 сард “ажиллаагүй” буюу түүний нэр дээр 4,184,266 төгрөгийн цалин бодож үүнээс туслах багшаар оронд нь ажилласан Э.Эрдэнэсүвдад 1,586,400 төгрөгийг өгч, үлдэгдэл 2,597,866 төгрөгийн цалин, салбар тавдугаар цэцэрлэгийн сахиулаар ажилласан гэх 3.Ууганбаатар 2019 оны 03 сараас 06 сард тус байгууллагад “ажиллаагүй” буюу түүний нэр дээр 2,642,760 төгрөгийн цалин тус тус бодож авч, зориулалт бусаар зарцуулсан нь анхан шатны баримтаар нотлогдож байна.

✓ Дуу хөгжмийн багш Д.Алтанцэцэгээс 2019 оны 04, 05 сард 300,900 төгрөг, туслах багш Ш.Оюунчимэгээс 2018 оны 12 сард 100,000 төгрөг нийт 400,900 төгрөгийн ур чадварын нэмэгдэл цалин, бүлгийн багш Д.Болормаагаас 2018 оны 07 сард 187,119 төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин тус тус олгоод буцаан авч, зориулалт бусаар зарцуулсан байна.

✓ Ур чадварын нэмэгдлийг нэр бүхий 5 албан хаагчдад журамд заасан хувь хэмжээнээс 5 хувиар илүү болон буруу бодож 389,400 төгрөг илүү, нэр бүхий 2 албан хаагчдад тушаалаар шийдвэрлэсэн хувь хэмжээнээс 5 хувиар бууруулж 80,000 төгрөг дутуу олгосон байна.

✓ Анхан шатны баримтууд, холбогдох албан хаагчдын өгсөн тайлбар тодруулга, албан байгууллагаас ирүүлсэн мэдээллийн огноо хоорондоо зөрүүтэй, ажлын цаг ашиглалтын бүртгэлийг нөхөж, худал, ажиллаагүй хүний нэрээр бүртгэдэг, ажлын цагийн тооцоог ажлын цаг ашиглалтын бүртгэл үндэслэж бүртгэдэггүй зэргээс тус сумын долдугаар цэцэрлэгт сахиулын албан тушаалд томилогдсон Л.Баттүвшинг 2018 оны 08 сард, долдугаар цэцэрлэгийн туслах багшаар ажиллаж байсан Ш.Наранцацралтыг 2018 оны 09 сарын 16-аас 2018 оны

12 сарыг дуустал хугацаанд, салбар тавдугаар цэцэрлэгийн туслах багш Г.Наранцацралтыг 2019 оны 06 сард, салбар цэцэрлэгт сахиулын албан тушаалд томилогдсон З.Ууганбаатарыг 2018 оны 08 сар, 2019 оны 02 сард тус тус ажилласан, ажиллаагүй алин болох нь анхан шатны баримтаар нотолж шийдвэрлэхэд хүндрэлтэй байна. Шалгалтын явцад З.Ууганбаатар нь ажил ихтэй байна гээд ирээгүй, Г.Наранцацралт, Ш.Наранцацралт нар нь тайлбар өгнө гэсэн ч ирүүлээгүй, Ш.Наранцацралтын гэр бүлийн хүн Л.Баттүвшинтэй холбогдоогүй, гэхдээ эхнэр Ш.Наранцацралтаар дамжуулан дээрх хугацаанд ажилласан эсэхийг тодруулж асуусан ба тайлбар ирүүлнэ гээд ирүүлээгүй.

Мөн шалгалтын явцад тус байгууллагын албан хаагчид ихэнх нь ээлжийн амралттай байсан учраас зарим албан хаагчид шалгалтад хамрагдсан, тайлбар тодруулга өгсөн албан хаагчдаас ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшуулалт цалингаа буцааж өгч байгаагүй гэсэн хариултууд үндэслэлтэй эсэх эргэлзээтэй байгаа тул дуу хөгжмийн багш Д.Алтанцэцэг, туслах багш Ш.Оюунчимэг, бүлгийн багш Д.Болормаа нараас бусад албан хаагчдаас ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшуулалт цалин авсан гэх асуудал нь анхан шатны баримтаар нотлогдохгүй, шийдвэрлэх боломжгүй байна. Иймээс холбогдох хуулийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэлээ.

✓ Туслах багшаар ажиллаж байсан Ш.Наранцацралтын 2018 оны 9-12 сард ажилласан, ажиллаагүй нь нотлогдохгүй байгаа учраас Э.Эрдэнэсүвд, Ш.Наранцацралт нарын 2019 оны ээлжийн амралтын олговрыг тооцох боломжгүй байна.

✓ Тус байгууллага нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр дотоодын хяналтыг хэрэгжүүлээгүй, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтыг хуурамчаар үйлдсэн байгаагаас санхүүгийн сахилга хариуцлага сул байна гэж дүгнэлээ.

ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан анхан шатны баримт хөтлөх, нөхөх заавар, Сангийн сайдын 2000 оны 69 дугаар тушаалаар баталсан “Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм” зэрэг хууль, журам, дүрэм, зааврыг байгууллагын албан хаагчдад судлуулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах

Дотоод хяналт шалгалтыг тогтмол хийж, гүйцэтгэлийг хянаж баримтжуулж байх

Багш, ажиллагсдын ажлын цагийг цаг бүртгэлийн цахим системээр бүртгэх

Албан хаагч нэг бүртэй эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулах

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх

Шалтгалтаар илэрсэн зөрчил, дутагдлуудыг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, албан шаардлагын биелэлтийг албан тоотоор хүргүүлэх

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Ж.ОЮУН

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА,
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Б.БАТТУЛГА

